



СОЁМБО



БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2020.04.16 №15 (10692)

Үнэ 500 төгрөг

Дугаар эрхэлсэн дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ

ОНЦЛОХ МЭДЭЭ

МОНГОЛ ЦЭРГИЙН ЭР ЗОРИГ, УР ЧАДВАРЫГ ХАРУУЛЛАА



БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын мандаттай энхийг сахиулах "UNMISS" ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний IX ээлжийн мотобудлагын батальон хүлээсэн үүргээ нэр төртэй гүйцэтгэсээр

байна. Энэ сарын 11-ний өдөр орон нутгийн цагаар 14.50 цагт Бэнтю хот дахь НҮБ-ын баазын шалган нэвтрүүлэх цэгийн гадна орон нутгийн зэвсэглэсэн долоон иргэн "Хил хязгааргүй

эмч нар" байгууллагын ажилтныг барьцаалах оролдлого хийснийг манай цэргийн алба хаагчид таслан зогсоож, хүмүүнлэгийн ажилтны амь нас, аюулгүй байдлыг бүрэн хангалаа. Тодруулбал, Юнити секторын

командлагчийн захирамжийн дагуу НҮБ-ын баазын гадна зэвсэггүй бүс /200 метр/-д эргүүлийн үүрэг гүйцэтгэж байсан ахлах ахлагч Н.Пунцаг захирагчтай "Зүчи" эргүүлийн бүлэг зэвсэглэсэн иргэдийн зүгээс олон улсын хүмүүнлэгийн байгууллагын ажилтныг хүч хэрэглэн авч явах гэсэн үйлдлийг таслан зогсоож, саатуулаад байгаа тухай мэдээг Ажиллагааны удирдлагын төвд илтгэсэн юм.

Үүссэн цагийн байдлыг үнэлж, батальоны Ажиллагааны удирдлагын төвөөс ахмад Б.Цээноровоор ахлуулсан сургагч ахлагч Д.Нямдаваа, А.Мягмарсүрэн нарын бүрэлдэхүүнтэй шуурхай бүлэг томилогдов. Тэд тухайн газарт очсон даруйдаа зэвсэглэсэн этгээдүүдтэй асуудлыг эв зүйгээр шийдвэрлэхийг оролдсон боловч манай эргүүл, хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байсан цэргийн алба хаагчид руу орон нутгийн хэлээр орилж, илтэд уурлан, 7,62 миллиметрийн АКМ загварын буу тулган сүрдүүлэн заналхийлж, хүмүүнлэгийн ажилтныг хүч хэрэглэн мотоциклд суулган авч

явах оролдлогыг хэд хэдэн удаа хийжээ.

Энэ үед цэргийн алба хаагчид үүссэн цагийн байдлыг үнэлж, хүмүүнлэгийн ажилтныг хамгаалахын тулд зэвсэглэсэн этгээдүүдийн эсрэг "Хүч хэрэглэх дүрэм"-ийн дагуу НҮБ-ын цэргийн сүр хүчийг үзүүлэн амаар анхааруулах, буу цэнэглэх, зэвсэг хэрэглэхэд бэлэн байгааг илтгэх зэрэг арга хэмжээнүүдийг шат дараалан авч хэрэгжүүлсэн байна. Гэсэн хэдий ч зэвсэглэсэн этгээдүүд шаардлагыг үл тоон улмаар хүмүүнлэгийн ажилтныг мотоциклд суулган зугтах оролдлого хийсээр байсан бөгөөд шуурхай бүлгийн даргын шийдвэрийн дагуу "Зүчи" эргүүлийн бүлэг дөрвөн нэгж техникээр өртөөчилсөн хаалт тавих аргаар саатуулан зогсоож аврах ажиллагааг эрсдэлгүй явуулсан. Энэ үед зэвсэглэсэн этгээдүүд зэвсэг хэрэглэн агаарт зургаа, бүлгийн машины урд хэсэгт газар луу гурван удаагийн буудлага үйлдэж манай цэргийн алба хаагчдыг зогсоохыг оролдсон нь амжилтгүй болжээ.

(Үргэлжлэл нь II нүүрт)

"АРАВТ"-ЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХУРАЛ ЦАХИМААР ЯВАГДАНА

Монгол Улсын Зэвсэгт хүчин ОХУ-ын БХЯ-наас зохион байгуулдаг "Олон улсын цэргийн наадам"-ын хүрээнд 2019 онд "Аравт" олон улсын морин цэргийн анхдугаар уралдааныг амжилттай зохион байгуулсан билээ. Монгол Улсын нутаг дэвсгэрт зохион байгуулагдсан энэхүү уралдааны талаар олон улсын шинжээчид хэд хэдэн зүйлийг дурдсан нь нэгдүгээрт, уралдаж өрсөлдөхөөс гадна хамтарсан сургалт бэлтгэлийн үүрэг гүйцэтгэж, монгол адууны уналга, эдэлгээтэй холбоотой олон зүйлийг оролцогч орнуудад таниулж чадлаа. Хоёрдугаарт, байгаль, цаг уурын хүнд

нөхцөлд цэрэг хүний бэлтгэл сургуулилт, эр зориг, тэсвэр хатуужил, авхаалж самбааг сорилоо. Гуравдугаарт, "Олон улсын цэргийн наадам"-ын хүрээнд явагддаг тэмцээнүүдээс хамгийн хүнд бөгөөд сонирхолтой, шигтгээ төрөл нь болсон талаар онцлон тэмдэглэж байсан юм. Монгол Улсыг олон улсад дахин сурталчлах "Аравт-2020" олон улсын морин цэргийн уралдааны төлөвлөлтийн хурлын тов гарчээ. Дэлхий нийтээр тархаад байгаа цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан 2020 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулахаар болсон байна.

ТОДРУУЛГА

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ШИЙДВЭР ГАРЛАА

Коронавирусийн цар тахлын улмаас үүссэн нөхцөл байдалтай уялдуулан Улсын онцгой комиссын 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 15 дугаар хуралдаанаар "2020 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагатай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" асуудлыг хэлэлцэн Улсын онцгой комиссын 2020 оны 8 дугаар тогтоол гарсан. Үүнтэй холбогдуулан БХЯ-ны СБТГ-ын Орон нутгийн хамгаалалт, улсын дайчилгааны хэлтсийн дарга, хурандаа С.ГАНБЯМБААС зарим зүйлийг тодрууллаа.

Цаг үеийн байдлаас шалтгаалан 2020 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагыг хязгаарлагдмал хүрээнд зохион байгуулах Улсын онцгой комиссын шийдвэр гараад байна. Тиймээс энэ удаагийн цэрэг татлагыг хэрхэн зохион байгуулах талаар мэдээлэл өгөхгүй юу?

-Коронавирусийн цар тахлын улмаас Засгийн газрын шийдвэрээр улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлыг 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл зарлаж, олон нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулахыг хязгаарлаад байгаа нь цэрэг татлагын бэлтгэлийг хангах, түүнийг зохион байгуулж, явуулахад хүндрэл үүсгээд байсан юм. Иймд үүссэн нөхцөл байдалтай уялдуулан 2020 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагыг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 250 дугаар тогтоолд заасан хугацаанд хязгаарлагдмал хүрээнд зохион байгуулж, явуулах саналыг Улсын онцгой комисст хүргүүлэн шийдвэрлүүлээ. Энэ жилийн нэгдүгээр ээлжийн цэрэг татлагын хувьд хүн амын нягтаршил их, корона вирусийн халдвартай болон ажиглалтад иргэдийг тусгаарлаад



байгаа, халдвар тархах эрсдэл өндөртэй Улаанбаатар хот, Баян-Өлгий, Дорноговь, Сэлэнгэ аймгуудад зохион байгуулахгүй. Харин бусад аймагт цэрэг татлага явагдана.

Бусад аймгуудад хэрхэн зохион байгуулах вэ?

-Улсын онцгой комиссын шийдвэрээр цэрэг татлагын үйл ажиллагааг Зэвсэгт хүчний Жанжин штаб, Хил хамгаалах Ерөнхий газар болон аймгуудын Засаг даргын Тамгын газар богино хугацаанд зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахаар ажиллаж байна. Энэ удаагийн цэрэг татлагаар Зэвсэгт

хүчний Жанжин штабаас тогтоосон хяналтын тооны дагуу аймаг, орон нутагт байрлах Хилийн цэргийн нэгтгэл, ангиудад тухайн аймаг, зэргэлдээх аймгуудаас хугацаат цэргийн алба хаагчийг татах ажлыг хуулийн дагуу зохион байгуулна. Энэ нь аль болох иргэдийг хол газар тэвэрлэхгүй байх, хөдөлгөөнийг хязгаарлах зорилгоор ингэж зохион байгуулж байгаа юм. Аймгийн Засаг дарга нарт Цэрэг татлагын товчоо, эмч нарын комиссыг сумдад ажиллуулахдаа нарийвчилсан график, төлөвлөгөө гаргаж, нэг дор таваас дээш цэрэгт татагдагч иргэнийг цуглуулахгүй байх, цэрэг татлагын үйл ажиллагааны үеэр ариутгал, халдваргүйтгэлийн горимыг чанд сахиж, улсын болон аймгийн онцгой комиссын шийдвэрийг чанд мөрдөж ажиллах талаар Батлан хамгаалахын сайдын үүрэг, чиглэлийг хүргүүлээд байна.

Энэ жил "Оюутан-цэрэг" сургалт явагдах эсэх талаар тодруулна уу?

-Засгийн газар, Улсын онцгой комиссын зүгээс коронавируст халдварын цар тахлын тархалтыг зогсоох чиглэлээр үе шаттай арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаатай уялдуулан оюутнуудын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах үүднээс энэ онд "Оюутан-цэрэг" сургалтыг явуулахгүй байх саналыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам гаргасныг Улсын онцгой комисс хэлэлцэн шийдвэрлэснийг уншигч та бүхэнд уламжилъя.

НИЙСЛЭЛИЙН ЗДТГ-ЫН ЦЭРГИЙН ШТАБ 95 НАС ХҮРЛЭЭ

Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Цэргийн штаб байгуулагдсаны 95 жилийн ой энэ сарын 9-ний өдөр тохиолоо. Шинэ төрлийн коронавирусууд өвчилж байгаа хүмүүсийн тоо дэлхий даяар нэмэгдсээр байгаа учир нэг дор олноор цугларахгүй байх, эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах, хамт олны ажлын ачаалал, эргүүл, жижүүр, хөл хорио зэргээс шалтгаалан "Өндөржүүлсэн бэлэн байдал"-ын энэ үед Нийслэлийн цэргийн штаб 95 жилийн ойн баярын хурлаа цахимгаар хийв.

Улаанбаатар хотын хүн ам,

суурьшил нэмэгдэхийн хэрээр төрийн батлан хамгаалах үйлчилгээний цар хүрээ, Цэргийн штабын үйл ажиллагаа, гүйцэтгэх үүрэг, орон тоо нэмэгдэж байгаа юм. Цэргийн штаб нь батлан хамгаалах үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, нэг стандарт, жишигт нийцүүлэн ажиллаж байгаа зэрэг олон амжилт, дэвшилтэйгээр 95 жилийн ойгоо угтлаа. Мөн түүхт ойдоо зориулж "Улаанбаатар хотын Цэргийн штабын түүхэн замнал" баримтат кино, "Нийслэлийн Цэргийн штаб" гэрэл зургийн цомгийг тус тус бүтээлээ.

ЯРИЛЦАХ ЦАГ

ЦЭРГИЙН ГЭРЭЭТ АЛБЫГ ӨРГӨЖҮҮЛНЭ

Зэвсэгт хүчний эрх зүйн шинэчлэлийн талаар ЗХЖШ-ын Бодлого, стратегийн төлөвлөлтийн газрын дарга, хурандаа Ч.ЦОГТЖАРГАЛТАЙ ярилцлаа.

Зэвсэгт хүчний стратегийн төлөвлөлтийн баримт бичгийг шинэчлэх хэрэгцээ, шаардлагын талаар Та тодруулахгүй юу?

-Бидний амьдарч буй 21 дүгээр зуунд олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдлын орчин ихээхэн өөрчлөгдөж, их гүрнүүдийн хооронд геостратегийн ноёрхол, ашиг сонирхлын төлөөх тэмцэл, өрсөлдөөн өргөн хүрээг хамарч, хөгжиж буй орнууд аюулгүй байдлаа хангах, тогтвортой хөгжлийн бодлогоо хэрэгжүүлэхэд төвөгтэй байдал үүсэж байна. Дэлхийн улс орнууд олон улсын болоод бүс нутгийн аюулгүй байдлын шинэ нөхцөл байдал, геостратеги, геополитикийн бодлогод гарч буй өөрчлөлтүүд, дайн, зэвсэгт тэмцэл явуулах үзэл баримтлал, цэргийн урлагийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн Зэвсэгт хүчний байгуулалт, түүний хөгжлийг хангах төлөвлөлтийг боловсруулахдаа нэн тэргүүнд шинжлэх ухаанч байдлаар ханддаг болжээ.

Монгол Улсын хувьд олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдлын орчны шинэ нөхцөл байдал, орчин үеийн цэргийн урлагийн онолд гарч буй зарчмын өөрчлөлт, дэлхийн улсуудад хийгдэж буй цэргийн шинэчлэлийн нийтлэг чиг хандлага, Монгол Улсын эдийн засгийн боломж,



нөхцөл, "Зэвсэгт хүчин нь мэргэжлийн цэрэгт суурилсан байх" гэсэн хуулийн суурь зарчимд нийцүүлэн стратегийн төлөвлөлтийн баримт бичгүүдийг шинэчлэхээр ажиллаж байна. Үүнийг бид Зэвсэгт хүчний эрх зүйн хүрээнд хийж буй цогц шинэчлэл гэж харж байна. Баримт бичгүүдээ шинэчлэхээр одоо мөрдөгдөж байгаа хуулиуд, түүнтэй уялдаж гарсан дүрэм, журам, зааврыг нийцүүлэх шаардлага гарч таарна. Ямар ч байсан энхий ээлжид баримт бичгүүдийнхээ төслийг үндэслэл, судалгаа сайтай боловсруулах нь бидний нэн тэргүүний зорилго. Үүний дараа салбарын хууль тогтоомж, түүнийг дагалдаж гарсан дүрэм, журам, зааврыг нийцүүлэх тухай асуудал яригдах болно.

(Үргэлжлэл нь II нүүрт)

“ГҮЙДЭГ”-ИЙНХЭН

Амжилттай хийж бүтээх их үйлсийн тэргүүнд ая тухтай орчин нөхцөл чухал үүрэг гүйцэтгэдэг гэдэгтэй хэн бүхэн санал нийлнэ. Тэгвэл Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын Үйлчилгээ аж ахуйн хэлтсийн хамт олныг тэрхүү ая тух, хэрэгцээ, шаардлага бүхнийг гүйцэлдүүлээд зогсохгүй бүх төрлийн хангалт үйлчилгээг түргэн шуурхай, цаг хугацаанд нь тасралтгүй зохион байгуулах үүргийг гүйцэтгэдэг “гүйдэг”-ийнхэн гэж хэлж болно. Хаана, хэнд, хэзээ, юу хэрэг болохыг тус хэлтсийн хамт олон хамгийн түрүүнд мэдэж, бүх талын бэлтгэл ажлыг хангадаг. Бэлтгэл ажил ямар хэмжээнд хангагдсанаас тухайн ажил, арга хэмжээ амжилттай болох эсэх нь хамаардаг. Энэ бэлтгэл ажил бол тэдний хийдэг зөвхөн нэг ажил нь. Үүнээс гадна биднийг эрүүл саруул байхад чухалд тооцогддог албан тасалгаа, ажиллах орчны цэвэрлэгээ, үйлчилгээ, тохижилт, цэцэрлэгжүүлэлт, угаалга, ариутгал, дулаан хэргээс гадна хувцас хэрэглэлийн нөхөн хангалт, цалин бодож, амт чанартай хоолоор хангах гээд тэдний оролцоогүй ажил, хүрэхгүй газар ховор юм.

Тус хэлтсийн ажилтан алба хаагчдын дийлэнх хувийг эмч, нягтлан бодогч, нярав, тогооч, үйлчлэгч, цахилгаанчин, мужаан, жолооч, слесарь зэрэг



төрийн үйлчилгээний алба хаагчид бүрдүүлдэг. Тэд хагасцэргийн зохион байгуулалттай ч цэргийнхэнтэй эн тэнцүү л цэрэгжилттэй байж үүрийн таван жингээс үдшийн бүрий хүртэл ажил үүргээ гүйцэтгэх нь олон. Тухайлбал, ЗХЖШ-ын бие бүрэлдэхүүн "Цугларалт" дохиогоор ажиллахад хэлтсийн удирдлага, эмч, нягтлан бодогч, нярав зэрэг албан тушаалтнуудаа зарлан мэдээллийг шуурхай хүргэж шаардлагатай бараа материалыг нь агуулахаас гаргах, Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн Цэргийн цагдаагийн ротын

цэргийн алба хаагчид, зохицуулагч офицерын хамт БХЯ, ЗХЖШ-ын гадна хамгаалалтыг зохион байгуулах жишээтэй. Мөн албаны өрөө, тасалгааг цэвэр цэмцгэр байлгадаг үйлчлэгч нар өглөө бүр эртлэн ирж ажил үүргээ гүйцэтгэжээдэг. Мөн гал тогооны тогооч, бэлтгэгч нарыг энд дурдахгүй өнгөрч боломгүй. Учир нь БХЯ, ЗХЖШ, Агаарын цэргийн командлалын бие бүрэлдэхүүнд жилд дунджаар давхардсан тоогоор 20160 хүнд нэг, хоёрдугаар халуун хоол, цайгаар үйлчилсэн ба хоногийн харуул манааны бүрэлдэхүүнд

буюу давхардсан тоогоор 6840 цэргийн алба хаагчид өдөрт гурван удаа дөрвөн удаагийн амт чанартай халуун хоол, цайгаар үйлчлээд байна. Түүнчлэн гадна, дотнын зочдын хүлээн авалтын зоогийг бэлтгэж үндэсний хоол, цайны гайхамшигийг мэдрүүлдэг алтан гартай тогооч нар энд ажилладаг. Тэдний ажил мөн л үүрийн таван жингээр эхэлдэг. Мөн тус хэлтсийнхний дийлэнх хувь нь оролцож, ажлын голыг нь нугалдаг чухал арга хэмжээний нэг бол "Бүх цэргийн Их хар

сүлдийг цэнгүүлэн тайх ёслол" юм. Энэхүү арга хэмжээнд "гүйдэг"-ийнхний гүйцэтгэх, бэлтгэх үүрэг бөгөөд идээ шүүс, арц утлага, хадаг зэргийг бэлтгэж оролцдог. Эдгээр нь энгийн жижиг зүйл мэт боловч чимхлүүр ажлуудынх нь нэг юм. Яг үүнтэй нэгэн адил ёслол хүндэтгэлийн ажиллагаа, цугларалт, хурал, зөвлөгөөн, олон улсын сургалт дадлага зэрэг бүхий л арга хэмжээнүүдэд энэ хамт олон оролцож байгаа нь төдийлөн харагддаггүй ч тэдний оролцоогүй үйл ажиллагаа гэж үгүй билээ.

ЯРИЛЦАХ ЦАГ

ЦЭРГИЙН ГЭРЭЭТ АЛБЫГ ӨРГӨЖҮҮЛНЭ

(Түрүүч нь I нүүрт)

Тэгэхээр стратегийн төлөвлөлтийн шинэчлэлийн нэг үндэс нь мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг бүрдүүлэхэд чиглэж байна гэж ойлгох нь зөв үү?

-Тэр мэдээж ойлгомжтой. Сүүлийн жилүүдэд Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний стратегийн цугларалт болон команд штабын сургуулиудыг "Зэвсэгт хүчний стратегийн төлөвлөлтийг шинэчлэх нь" сэдвийн хүрээнд зохион байгуулж явуулсан. Эдгээр сургууль, дадлагаар Зэвсэгт хүчний стратегийн төлөвлөлтийн баримт бичгийг орчин үеийн нөхцөл байдалд нийцүүлэн шинэчлэх шаардлагатай болсон нь тодорхой болсон. Нөгөө талаас Монгол Улсын Зэвсэгт хүчин мэргэжлийн цэрэгт суурилсан байхын тулд стратегийн төлөвлөлтийг шинэчлэх шаардлагатай гэдэг нь мөн тодорхой харагдсан.

Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар УИХ-д өргөн барьсан. ЗХЖШ-аас энэ хуулийн төсөлд ямар санал хүргүүлсэн бэ?

-Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хоёр гол асуудал байгаа юм. Нэгдүгээрт, өнөөдөр Монгол Улсын Зэвсэгт хүчин төмөр зам, авто зам, барилга байгууламж зэрэг улс орны томоохон бүтээн байгуулалтын ажлыг бие даан гүйцэтгэх болсон. Энэ нь улс орны стратегийн бүтээн байгуулалтын ажлуудыг Зэвсэгт хүчин нуруун дээрээ үүрч яваа гэсэн үг. Үүнийг зарим хүн "Хувийн хэвшлийн ажлыг Зэвсэгт хүчин хийж байна" гэж шүүмжилдэг ч энэ нь цаад утгаараа стратегийн түвшинд ямар чухал ач холбогдолтой гэдгийг нь харах ёстой.

Тайван цагт Зэвсэгт хүчний үндсэн үүргүүдийн нэг нь стратегийн бүтээн байгуулалтын ажлуудыг гүйцэтгэх бөгөөд барилга-инженерийн цэргийг төрлийн цэргийн түвшинд хөгжүүлэх гэсэн том бодлого юм. Дараагийн эрх зүйн зохицуулалт нь кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх нэгжийг бий болгох тухай. 21 дүгээр зуун бол мэдээллийн технологийн эрин зуун бөгөөд энэ зуунд мэдээллийн технологи хурдацтай хөгжиж, сүлжээ үүсгэн, дэлхийг бүхэлд нь бүрхсэн кибер орон зайг бүрдүүлж байна. Өнөөдөр энэхүү кибер орон зай дахь халдлагын тоо, төрөл, хор хохирлын хэмжээ жил ирэх тусам нэмэгдэх болсон. Үүний эсрэг дэлхийн улсууд кибер цэргийг байгуулж, энэ орон зайд аюулгүй байдлаа хангахыг хичээж байна. Монгол Улсын хувьд ч ялгаагүй энэхүү шинэ төрлийн заналхийллээс урьдчилан сэргийлэх, эсэргүүцэн тэмцэхэд бэлэн байх үүднээс энэ төрлийн цэргийг байгуулж, бэхжүүлэх шаардлага бий болсон.

Үүнийг дагаад эрх зүйн шинэчлэлийн олон ажил үргэлжлээд гарч ирэх нь ...

-Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсны дараа яригдах асуудал. Ер нь шинэчлэн батлагдсантай уялдуулан нийцүүлэх эрх зүйн баримт бичгүүд олон бий. Дээрх эрх зүйн шинэчлэлүүдээс гадна "Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги-2030" баримт бичгийн нэгдүгээр шат болох "Зэвсэгт хүчний байгуулалтыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр" энэ онд хэрэгжээд дуусаж байгаатай холбогдуулан түүний дараагийн шат болох "Зэвсэгт хүчний байгуулалтыг 2024 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр", түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг ЗХЖШ-аас боловсруулаад дуусаж байгаа. Хөтөлбөр Засгийн газраар батлагдана.

Хөтөлбөрт юу тусгаж байна вэ?

-Мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчний бэхжүүлэх, төрлийн цэргийг хөгжүүлэх гээд олон асуудлыг тусгаж байгаа. Үүнээс онцлох хоёр сэдэв байна. Нэгдүгээрт, Батлан хамгаалах аж үйлдвэрийн бааз суурийг бий болгох, хоёрдугаарт, цэргийн гэрээт албыг хөгжүүлэх тухай асуудал юм. Бид мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчин гэхээр зөвхөн офицер, ахлагч гэж ойлгодог. Тэгвэл мэргэшсэн цэргийн нэг нь яахын аргагүй цэргийн гэрээт алба хаагч. Бид хугацаат цэргийн алба хаагчаа нарийн мэргэжлээр сургаж, дадлагажуулдаг ч төд удалгүй халагдаад явж байна. Сургаж, сургачааад Зэвсэгт хүчин эргээд ашиглаж амждаггүй. Мэдээж тухайн хугацаат цэргийн алба хаагч хүнийхээ хувьд олон давуу боломжийг өөртөө бий болгосон дайчилгааны бэлтгэл нөөц болж байгаа нь хамгийн чухал. Гэхдээ цаашдаа сургаж мэргэшүүлсэн бүрэлдэхүүнээ илүү үр дүнтэй ашиглах нь бидний зорилго байх бөгөөд үүнийг шийдвэрлэх гол арга зам нь цэргийн гэрээт алба хаагч. Цаашдаа цэргийн гэрээт алба хаагчдынхаа тоог нэмэгдүүлэх бодлого баримтлан, эрх зүйн зохицуулалтыг ч хийхээр ажиллаж байна.

Тухайлбал ...

-Олон боломжийг нээж өгнө. Үүний нэг нь цэргийн хуаранд ажлын таван өдрөөр байлгахгүй. Яг л офицер, ахлагч нар шиг өглөө ажилдаа ирж, орой гэртээ харьдаг, цалингаа гар дээрээ бүтэн авдаг болно. Цалингийн ангиллыг нь ч гэсэн ЗХЖШ-аас нэмэгдүүлэх бодлого баримталж байна. Харин статусын хувьд хэвээрээ. Цэргийн гэрээт алба хаагчдыг нэгдүгээрт, барилга-инженерийн ангиудад, хоёрдугаарт, мэргэжлийн тусгай ангиудад авна. Цэргийн гэрээт албыг хөгжүүлэх бодлого нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн ажил, орлоготой залуусын тоог нэмэгдүүлэх, улс орны бүтээн байгуулалтад оролцуулах тухай шийдвэртэй нийцэж байгаа юм.

МОНГОЛ ЦЭРГИЙН ЭР ЗОРИГ, УР ЧАДВАРЫГ ХАРУУЛЛАА

(Түрүүч нь I нүүрт)

Түүнчлэн тухайн үүссэн цагийн байдлыг үнэлж шуурхай бүлгийн даргын гаргасан шийдвэрийг үндэслэн дэд ахлагч Э.Лхагвасүрэн ахлагчтай эргүүлийн хоёрдугаар бүлэг (дэд ахлагч Д.Даш-Өлзий, Ж.Отгончулуун, С.Цэнд-Аюуш) эр зориг гарган, үүргээ мэргэжлийн түвшинд гүйцэтгэсэнээр уг ажилтныг "Хубилай" баазын байрлалд авч ирсэн ба тэд мандатад заагдсан үүргээ биелүүлэв.

Энэхүү үйл явдлын мөрөөр Мужийн зохицуулагч хатагтай Хироко Хирахара, Өмнөд Судан улсын Ардын батлан хамгаалах хүчний 4 дүгээр дивизийн захирал, хошууч генерал Карло Куал Руаи нар хүрэлцэн ирж болсон үйл явдлын талаар тодруулан батальоны удирдлагатай уулзсан юм. Уулзалтын үеэр хатагтай Хироко Хирахара "Монгол Улсын Зэвсэгт хүчний батальоны цэргийн алба хаагчид зэвсэглэсэн этгээдүүдийн заналхийллийг үл тоон, эрсдэлийг сөрөн харуу буудлага хийлгүйгээр хүмүүнлэгийн ажилтны амь нас, аюулгүй байдлыг хангасанд сэтгэл өндөр байна. Монгол цэргүүд шаардлагатай үед зэвсэг хэрэглэх бүрэн чадвартай, мэргэжлийн цэргүүд гэдгээ дахин баталлаа. Нэгдсэн Үндэстний Байгууллага та бүхэнд ямагт итгэж, та бүхнээр бахархдаг" хэмээн онцолсон юм. Мөн тэр бээр

хошууч генерал Карло Куал Руаид хандан Өмнөд Суданы Ардын батлан хамгаалах хүчний цэргүүд дахин ийм үйлдэл гаргавал хатуу арга хэмжээ авна" хэмээн мэдэгдэв.

Харин хошууч генерал Карло Куал Руаи болсон үйл явдалд харамсаж байгаагаа илэрхийлэн, цагдаагийн мөрдөн байцаагч, түүнийг дэмжсэн Өмнөд Суданы Ардын батлан хамгаалах хүчний цэргийн алба хаагчид буруутайг цохон тэмдэглэж, Мужийн зохицуулагч болон монгол цэргүүдээс уучлал хүссэн юм. Учир нь хүмүүнлэгийн ажилтныг барьцаалах оролдлого хийж, эмх замбараагүй байдал үүсгэсэн этгээдүүд нь энгийн хувцас өмссөн Өмнөд Суданы Ардын батлан хамгаалах хүчний 4 дүгээр дивизийн цэргийн алба хаагч болон орон нутгийн цагдаагийн алба хаагч нар байсан нь уг үйл явдлын дараа тогтоогдсон юм.

Ийнхүү ахмад Б.Цээноров, сургагч ахлагч Д.Нямдаваа, А.Мягмарсүрэн, ахлах ахлагч Н.Пунцан, дэд ахлагч Э.Амарсайхан, Т.Баяраа, М.Алтаншагай, Б.Батсүмбэрэл, Ц.Ганбаатар, Д.Даш-Өлзий, Э.Лхагвасүрэн, С.Цэнд-Аюуш, Ж.Отгончулуун, О.Цэрэндэндэв, С.Соёлмөнх нар эрсдэлтэй нөхцөл байдалд эр зориг, мэргэжлийн ур чадвараа харуулан НҮБ-ын мандатаар хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж, монгол цэргийн нэр хүндийг өндөрт өргөлөө.

Ахмад Д.МЭНДБАЯР

Редакцын шууданд

ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ

Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын 2019-2020 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу Зэвсэгт хүчний артиллерийн мэргэжлийн офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчдын дунд "Артиллерийн буудлага, гал удирдах бэлтгэлийн уралдаан"-ыг 2019 оны 12 дугаар сарын 20-ноос 2020 оны 4 дүгээр сарын 15-ныг хүртэл, 4 дүгээр сарын 20-ноос 10 дугаар сарын 5-ныг хүртэл хоёр үе шаттайгаар зохион байгуулж байна. Нэгдүгээр шатны дүнгээр офицеруудаас дэд хурандаа М.Эрдэнэтөгс (186), дэд хурандаа Г.Баярхүү (167), дэд хурандаа Д.Төмөрхуяг (120), ахлах дэслэгч Б.Дорждэрэм (120), ахлагч нараас ахлах ахлагч П.Жавхлантагс (256), ахлах ахлагч П.Батхүлэг (256) нар амжилттай оролцлоо.

Дэд хурандаа С.ГАНБАЯР

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ЦЭРГИЙН ШТАБ

➢Насан туршийн боловсролын төвтэй хамтран "Эх оронч Монгол хүн" уран уншлагын цахим уралдааныг явууллаа. Уралдаанд 20 гаруй бүтээл оролцсон бөгөөд цахим хандалт, шүүгчдийн багийн онооны нийлбэрээр эхний таван байрыг шалгарууллаа. Нэгдүгээр байрт Т.Тунгалагтуяа "Энхийн төлөө", хоёрдугаар байрт О.Батцэнгэл "Эх орны тухай" шүлгийн түүвэр, гуравдугаар байрт У.Үүрийнтуяа "Нар зөвийн эх орон", дөрөвдүгээр байрт Ц.Буянхүү "Хөх даалимбан тэрлэг", тавдугаар

байрт Б.Ганболд "Монгол зохиолч" шүлгээрээ тус тус шалгарлаа. Уг уралдаан нь гамшигын өндөржүүлсэн бэлэн байдал зарлагдсан энэ цаг үед хүүхэд, залуус эх оронч үзлийг төлөвшүүлэхэд чиглэсэн оновчтой арга, хэлбэрээр зохион байгуулагдсанаараа онцлог болж чадсан юм.

➢Коронавирусийн цар тахлын улмаас гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын горимыг алдагдуулалгүйгээр Өмнөговь аймгийн сумдын орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө, түүний ажлын зургийг боловсруулах, томилгоот нэгжүүдэд бие бүрэлдэхүүнийг томилгоожуулах ажлыг зохион байгуулж, аймгийн Засаг даргаар батлуулсан төлөвлөгөөг сумдын Засаг дарга нарт гардуулан өглөө.

Дэд хурандаа Б.БЭРХГАЛТ

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН АЛБА

Цагдаагийн Ерөнхий Газраас нийт иргэд, жолооч нартаа коронавирусийн эсрэг нөлөөллийн аянд нэгдэж амны хаалтаа тогтмол зүүж, мөн өдрийн цагт тээврийн зорчсгийнхээ ойрын гэрлийг асааж хөдөлгөөнд оролцохыг уриалж байна.

Ахлах дэслэгч Л.ГАНХУЯГ

123 дугаар анги

➢Ховд аймгийн Жаргалант сумын Буянт багт оршин суудаг бүтэн өнчин эгч, дүү нарыг гэртэй болгох

аяны хүрээнд ангийн байнгын бие бүрэлдэхүүн сэтгэлийн хандив өргөж 558000 төгрөгийн туслалцаа зүүлэв.

➢Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалаас өгсөн үүргийн дагуу дадлагад суурилсан "Бататгах" сургалтыг явуулж, үр дүнг нь тооцон ажиллаж байна.

АХМАД Э.ЗОЛЗАЯА

013 дугаар анги

2019-2020 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу сургуулийн жилийн нэгдүгээр үеийн төгсгөлийн шалгалтыг явууллаа.

Хошууч Ж.ТӨГСМАНДАХ

084 дүгээр анги

Салбарын офицерууд, даргалах албан тушаалын ахлагч нартай "Тайван цагт үүрэг гүйцэтгэх томилгоот салбар бүлгийн үүрэг" сэдвээр заах арга зүйн цугларалтыг явууллаа.

Мөн оролцсон бүрэлдэхүүн болон ангийн офицер, ахлагч, ажилтан албан хаагчдад инженер саперын салаа, томилгоот галын салаа "Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд дэмжлэг үзүүлэх салааны ажиллагаа", "Орон тооны бус галын салааны ажиллагаа", "Үйлдвэрлэлийн осол болсон тохиолдолд инженер саперын бүлгийн ажиллагаа" сэдвүүдээр үзүүлэх сургууль, тактик жагсаалын хичээлийг зохион байгууллаа.

Ахмад Д.МӨНХ-ӨНӨР

БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ БА ЦЭРГИЙНХЭН



ИХ ҮЙЛСИЙН ЭЗЭД ...

Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид эх орноо батлан хамгаалахаас гадна улсынхаа хөгжил, бүтээн байгуулалтад жинтэй хувь нэмрээ оруулж ирсэн түүхтэй. "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-ын дагуу Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлээд жил гаруй хугацаа өнгөрөөд байна. Энэхүү нэн чухал бөгөөд нэр хүндтэй ажилд Зэвсэгт хүчний алба хаагчид оролцож байгаа. Тэд төмөр замын доод бүтцийн буюу газар шороо, дөрвөлжин болон дугуй хоолой, гүүрний бүтээн байгуулалтад оролцоходоо өдөр, шөнө, цаг агаарыг үл харгалзан шаргуу хөдөлмөрлөснөөр гол ажлыг нь нугалж байна. Манай улсын эдийн засгийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэхэд тус бүтээн байгуулалтын



Ахлагч Б.ЗОРИГТБААТАР

байгуулалтад оролцох азтай завшаан тохиосон байна. Ахлагч Б.Зоригтбаатар "Хүн нэг бүр технологийн ажлаа сайтар мөрдөж байгаа. Лабораторийн ажил маань төлөвлөгөөний дагуу хэвийн явагдаж байна. Ул хөрснөөс дээж авч хяналтын лабораторидоо баталгаажуулдаг. Хөрсний бүрэн шинжилгээ хийгддэг гэсэн үг. Иж бүрэн лабораторитой гарч ирсэн учраас ажлын явцад тулгарах хүндрэл, бэрхшээл тохиолдсонгүй" гээд цаашид хувийнхаа болон хамт олныхоо ажлын бүтээмжийг улам нэмэгдүүлэх талаар төлөвлөгөө гарган мөрдөж ажиллана гэлээ.

Мөн онцлох ёстой хүмүүсийн тоонд жолооч нар зүй ёсоор багтана. Та ч үүнтэй санал нийлэх байх. Тэд хаана ч, хэзээ ч дөрвөн дугуйтаараа саадгүй хүрч очдог, хат суусан хүмүүс гэхэд нэг их буруудахгүй. Энэхүү залгамж халаа өнөөдрийн Зэвсэгт хүчний төмөр замын бүтээн байгуулалтын талбарт ч бий. Жолооч нар маань энд өдөр, шөнийг үл



Б.ГАНБОЛД

харгалзан 24 цагаар хоёр ээлжээр үүрэг гүйцэтгэдэг. Тэдний нэг нь Б.Ганболд. Ажил, амьдралын туршлага их, насаараа хамгийн ахмад нь учраас залуус үе үеэс өмнүүр нь орж гүйгээд ажлыг нь хөнгөвчлөх гээд байдаг гэнэ. Тэрээр үүрэгт ажлаа өөрөө хийхийг эрмэлздэг бөгөөд бусдын гарыг хардаггүй. Түүний талаар залуус "Өмнүүр нь орж гүйгээд байдаг нь хүндэлж байгаагийн шинж, тэрнээс биш Ганболд ах маань хэдэн жолооч нартаа нэвтэрхий толь шиг хүн. Бид болохгүй зүйл гараад ирвэл түүнийг хайгаад л эрэл сурал болдог. Харин биднийг өөрийнхөө үүрэгт ажилд ойртуулдаггүй. Ажилдаа эзэн болсон хүн гэвэл түүнийг л хэлнэ" гэж ихэд сайшааж байв. Түүний үүрэгт ажил нь далаанд ашиглагдах шороог тээвэрлэн заасан цэгт буулгаж, автогрейдерээр тэгшлэхэд бэлэн болгодог аж. Тухайн газрын

онцлогоос хамаараад өдөртөө хэдэн ч удаа зөөж болно. Кабиндаа суугаад жолооч, харин кабинаасаа бугаа л засварчин болно. Техник хэрэгслийнхээ бүрэн бүтэн байдлыг шалгаж, эвдрэл, гэмтэл байгаа бол цаг тухайд нь шуурхай засаж, хөдөлгөөнд оролцуулахад бэлэн болгох зэргийг мөн л өөрөө хариуцна. Ер нь жолооч гэдэг нэрийн ард олон үүрэг хамт байдаг гэдгийг Б.Ганболдын ажлаас харж болно.

ЭХ ОРНОО ХӨГЖҮҮЛЭХ ҮЙЛСЭД ХАМТДАА ЗҮТГЭЕ!
Зэвсэгт хүчний 338 дугаар ангийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженер, ахлах дэслэгч Х.НАНДИН-ЭРДЭНЭ:



"Би 2010 онд ШУТИС-ийг барилгын инженер мэргэжлээр төгссөн. Бага байхаасаа л барилгачин болохыг мөрөөддөг байсан. Яагаад гэвэл, аав маань нутаг усандаа "Өндөр ах" гэж хүндлэгдсэн, гарын ур дүйтэй мужаан бас мянгат малчин хүн байсан. 1981-1984 онд Хүндэт харуулын 032 дугаар ангид цэргийн алба хаасан. Аавынхаа ажилд тусалж, зурахыг нь зурж, тайрахыг нь тайрч өгдөг байсан минь энэ мэргэжил рүү хөтөлсөн гэж боддог. Анх барилгын цэргийн ангид ороод цэргийн хүмүүсийн өндөр сахилга баттай, дүрэм, журамтайг нь хараад бахархаж байлаа. Бүтээн байгуулалтад ажиллаж буй бидний хувьд анхаарал болгоомж, дадлага, туршлага, үүрэг хариуцлага маш чухал. Иймд бие бүрэлдэхүүндээ хандаж анхаарал болгоомжтой байж, хийж буй ажилдаа эзэн нь болж, эх орноо хөгжүүлэх үйлсэд хамтдаа зүтгэхийг уриалж байна. Аюулгүй ажиллагаа бол амжилтын үндэс юм.

ААВ, ЭЭЖДЭЭ БАЙШИН БАРЬЖ ӨГНӨ
Зэвсэгт хүчний 338 дугаар ангийн түрүүч Т.БАРХАС:



"Би 2019 оны хоёрдугаар ээлжээр Зэвсэгт хүчний 338 дугаар ангид

хугацаат цэргийн албанд татагдсан. Цэргийн албанд татагдахын өмнө тус ангид засал чимэглэлчнээр ажилладаг байсан болохоор цэргийн албаны талаар тодорхой мэдлэгтэй гэж өөрийгөө боддог байв. Одоо харин тэс өөр гэдгийг мэдэрч байна. Цэргийн тангараг өргөөд зогсож байхдаа өөрөөрөө, нөхдөөрөө бахархах сэтгэгдэл төрж байлаа. Гэхдээ бахархаад өнгөрөх биш тангарагтаа үнэнч байх нь чухал. Эх орныхоо өнцөг булан бүрээс цэргийн албанд ирсэн залуус нэг казармд байрлаж, бие биеэсээ суралцаж, бүдэрсэн нэгнээ бүснээс нь татаад босгох, цангасан нэгэнтэйгээ цайгаа хуваагаад уух, урагдсан хувцсаа оёх, гэр орон, байшиндаа засвар хийх зэрэг их зүйлийг сурч байна. Энэхүү бүтээн байгуулалтын ажилд оролцох боломж олгосон ангийн удирдлага, бие бүрэлдэхүүндээ баярласнаа илэрхийлье. Ийм боломж цэргийн алба хааж байгаа хэн бүхэнд олдоод байхгүй. Хийсэн, бүтээсэн ажлаа хараад сэтгэл нь хөдөлдөггүй хүн ховор байх. Тун удахгүй бүтээн байгуулалтаа хараад эрч хүч, урам зориг авна гэхээр сэтгэл өөдрөг байна. Цэргээс халагдаж очоод өөрийн хуримтлалаараа аав, ээждээ байшин барьж өгч ачийг нь хариулна.

ЗОХИЦУУЛАГЧИЙН ҮҮРЭГ ЧУХАЛ

Бүтээн байгуулалтын талбарт цөөнгүй тооны Тээврийн цагдаагийн албаны зохицуулагч нар ажилладаг. Тэд тус бүтээн байгуулалтад оролцож буй техник хэрэгслүүдийг болон орон нутгийн тээврийн хэрэгслийг технологийн зам дээр хөдөлгөөнд оролцоход нь аюулгүй байдлыг нь хангуулах чиг үүрэгтэй. Энд үүрэг гүйцэтгэж буй цагдаагийн ахмад Б.Мягмарбат, ахлах дэслэгч С.Сэр-Од нар цэргийн алба хаагчидтай ажиллахад хялбар, сахилга баттай, өндөр зохион байгуулалттай, дүрэм, журмаа сайтар



Ахлах дэслэгч С.СЭР-ОД

мөрддөг талаар онцолж байсан юм. Ахлах дэслэгч С.Сэр-Од өөрийгөө голдог ч гэлээ бичиж туурвих сонирхолтой. Тэрээр энд байх хугацаандаа шүлэг тэрлээд амжсан гэнэ. Тэрхүү шүлгээр нь энэ удаагийн сурвалжилгаа өндөрлөө.

ГАНГАН ГОВИЙН ДУНДУУР АЛТАН БУС ШИГ ГАН ЗАМ

Ингэ нь ивлэж, ботго нь амрах
Ижийн сэтгэл шиг тэнэгэр говьд
Инженерийн ангийн хөдөлмөрчид
Ирээдүйн жаргал руу Монголыг хөтөлнө
Зэрэглээт говийн элсэн дундуур
Зэвсэгт хүчин цэрэглэн хөдөлж
Гартаа буу биш хүрз барьж
Ганган замыг дархлан урласан юм
Цэрэг эрсийн өргөсөн тангараг нь
Цэгцэрсэн жагсаалын сүр болсон юм
Ганцхан эх орны төлөө өргөсөн андгай нь
Галт тэрэг хөдлөх зүтгүүр болсон юм
Цэцэн бууны овооны оронд
Цэхийг харах дуран шаггайж
Хүчит танкийн хүнгэнэх чимээг
Хүнд техникийн бүтээлээр сольсон юм
Хөгжил дэвшлийн бүтээл ундарч
Хөдөлгүүрийн дуу тасраагүй юм
Мятаршгүй хүчээр гагнасан замаар
Маргаашийн сайхан руу зүтгүүр хөдөлнө



Нүүрийг бэлтгэсэн ахлах ахлагч Г.БАТ-ЭРДЭНЭ

НАДАД САНАЛ БАЙНА

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН АГСАМЖ БУЮУ "РАТНИК" ТӨСӨЛ

Дэлхийд Зэвсэгт хүчнээрээ тэргүүлэгч орнууд цэргийн алба хаагчдын агсамжийн асуудалд ихээхэн ач холбогдол өгч шинээр зохион бүтээх, сайжруулах талаар идэвхтэй ажиллаж байна. Тухайлбал, НАТО-ийн гишүүн АНУ, Их Британи улс нь цэргийн зардлын худалдан авалтын төсвийн 60 орчим хувийг байлдааны ажиллагаанд шууд оролцдог тагнуулч, явган цэрэг, инженерийн мэргэжилтнүүдийн нэг бүрийн хамгаалах хэрэгсэлд зарцуулдаг байна.

Шинэ агсамжийг бүтээх үйл явц нь өндөр технологийн төсөл болдог тул санхүүжилтийн хязгаарлагдмал боломжтой улс орнуудад хүндхэн тусдаг. 1940-өөд оны АНУ-ын цэргийн алба хаагчдын хэрэглэж байсан агсамж нь 16 килограмм орчим жинтэй, 170 ам.долларын үнэтэй

байжээ. Харин Вьетнамын дайны үед агсамжийн чанар сайжрахын зэрэгцээ үнэ нь 1100 ам.доллар болсон байна. Орчин үед АНУ-ын цэргийн алба хаагчдын хэрэглэж байгаа агсамжийн нэг бүрийн үнэ нь 17.500 ам.доллар хүрсэн бөгөөд зарим эх сурвалжид дурдсанаар 10 гаруй жилийн дараа агсамжийн нэг бүрийн үнэ 28-60 мянган ам.долларт хүрэх ажээ.

Афганистан, Ирак улсад үүрэг гүйцэтгэж байгаа АНУ-ын цэргийн алба хаагчид нь хуягт цээживч, нийлмэл материалаар хийсэн дуулга, хамгаалалтын нүдний шил, галд тэсвэртэй хувцас, шөнийн харааны хэрэгсэл, лазеран бай заагч зэрэг зүйлээр заавал хангагддаг. Ингэснээр агсамжийн бүрдэлд 80 гаруй зүйл багтаж, 34 килограмм орчим жинтэй болдог.

Агсамжид тавигдах нийтлэг, тусгай шаардлагуудыг дараах байдлаар багцлан авч үздэг. Үүнд:

-Цаг уурын ба физик-газар зүйн төрөл бүрийн нөхцөлд явагдсан цэргийн ажиллагааны туршлага, сургамжид тулгуурласан;

-хөдөлгөөнд буюу буудлага хийх үед саад болохгүй байхаар загварыг бүтээх;

-өнгөлөн далдлалтын хэв шинжийг агуулахын зэрэгцээ дуу чимээ гаргахгүй байхаар хийгдсэн байх;

-халаас, шилбэ, бүч, гох зэрэг нэмэлт бэхлэгээ, байрлал нь агсамжийн стандартад нийцсэн байх ба хурдан өмсөж, тайлах боломжтой байх;

-төрөл бүрийн болон өгөгдсөн нөхцөлд үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай

тоноглол, хэрэгсэл (зэвсэг, тоноглол)-ийг оновчтой байрлуулах боломж бүхий хийцтэй байх;

-нийт жин нь удаан хугацаанд үүрэг гүйцэтгэхэд тохиромжтой бага жинтэй байх зэрэг болно.

Үүнээс гадна цэргийн алба хаагчийн хувцас, хэрэгслийн чанарын шинж нь даавуу болон дулаалгын материалын сонголтоос ихээхэн хамаардаг байна. Учир нь даавуу болон дулаалгын материал нь хүрээлэн буй орчны нөлөөлд тэсвэртэй (ус нэвтрүүлэхгүй байх), агаарыг чөлөөтэй нэвтрүүлж, гадагшуулах (хөлрөлт) боломжтой байх шаардлагыг хангасан байх ёстой. Энэхүү шаардлагад нийцэхүйц материалд мембран даавуунууд багтдаг. Мөн "го-

текс", "диатекс" болон лазерын технологиор бий болгосон бусад даавуу багтдаг.

ОХУ, АНУ нь агсамжийн судалгаа шинжилгээ, зохион бүтээх ажилд хамгийн амжилттай яваа орнууд юм. ОХУ-ын шинэ үеийн "Ратник" загварын агсамж, АНУ-ын "PM SWAR" загварын агсамжууд нь зориулалт, иж бүрдлийн хувьд хоорондоо төстэй. Хуяган цээживчийн ашиглалтын ба хамгаалалтын шинжийн тухайд "Ратник" илүү хараалах бол тагнуулын хэрэгслээрээ "PM SWAR" давуутай гэж судлаачид үздэг. Мөн "PM SWAR" агсамж нь практик хэрэглээний ихээхэн туршлага хуримтлуулсан бол "Ратник" загварын агсамжийг зөвхөн Сири улсад л туршсан учир туршлага, сургамж гэх зүйл харьцангуй бага юм.

ОХУ-ЫН ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН АЛБА ХААГЧ НЭГ БҮРИЙН ХОЁР ДАХЬ ҮЕИЙН "РАТНИК-2" АГСАМЖ

-Эрчим хүч хангалтын систем (цэнэглэх станц, аккумуляторын батареи);

-удирдлага ба тагнуулын систем (коммутатор системийн "Глонасс" нэг бүрийн холбооны модуль, удирдлагын хоёр пульта, байг таних, дагалдан хянаж, солбицлыг тодорхойлох модуль-Фара-ВР, хол хэмжигч, мэдээллийн планшет);

-хөнөөлийн хэрэгсэл (автомат АК-12);

-Амьдралыг тэтгэх систем (олон зориулалтын үүргэвч нь дотроо эмнэлгийн тусламж үзүүлэх, халдваргүйтгэл хийх хэрэгсэл, хорхой шавжнаас хамгаалах тор, усны шүүлтүүр, майхан ба уутан хөнжил, далдлалтын хэрэгсэл, саперын жижиг хүрээ зэрэг зүйлийг багтаасан);

-хамгаалалтын хэрэгсэл (комбинзон, хуяган цээживч, хамгаалалтын нүдний шил, өвдөг ба тохой хамгаалах хэрэгсэл, нүүр хамгаалах халхавч).

Дуулга нь таван метрийн зайнаас гар бууны сумны шууд онолтоос цэргийн алба хаагчийн амийг аварч болох хэрэгсэл юм. Дуулганы дотор талд холбооны систем бүхий дуран, монитор байрладаг. Бууны хараанаас дүрсийг шууд дуран, монитор дамжуулдаг байна.

Ерөнхий зориулалтын цэргийн цээживч (15 килограмм хүртэл жинтэй) нь их бууны сумны хэлтэрхий, хүйтэн зэвсэг ба буудлагын зэвсгийн сумнаас хамгаалдаг. Мөрөвч, хажуу тал, бүсэлхийн хэсгийн хамгаалах хэрэгсэлгүйгээр цээживчийн стандарт жин есөн килограмм орчим байдаг байна.

5,45 миллиметрийн автомат АК-12 нь Калашниковын хийцийн бууны орчин үеийн нэг загвар юм. Өмнөх загваруудаас ялгаатай нь уртыг мөрлөгөөр тохируулах ба янз бүрийн хараа, гол төмөр доорх суулгавч, гранатомёт, дэнлүү зэрэг зүйлийг бэхлэх Пикатинийн хийцийн самбараар тоногдсон юм. "Ратник" агсамжид зориулан автомат, пулемёт, мөргөн буудагчийн винтовт тохирох хэд хэдэн гэрэллэг дуулганы мэдрэмтгий харааг бүтээжээ.

Өндөр түрийтэй гутал нь хөлд сайн сууж өгдөг бөгөөд зуны ба өвлийн гэсэн хоёр төрөл байдаг. Орчин үеийн цэргийн гутлыг шир болон дөвшилтэд технологи бүхий материалаар хийжээ. Иймээс 24 цагийн турш өмсөхөд ямар ч асуудалгүй аж.

Тусгай нүдний шилийг 350 м/сек-ын хурдтай нисэж буй зургаан миллиметрийн диаметртэй хэлтэрхийний онолтыг тэсвэрлэх



боломжтой тусгай шилээр бүтээжээ.

Удирдлага ба холбооны тагнуулын цогцолбор "Стрелец" нь бүхэлдээ компьютер бөгөөд

түүний тусламжтайгаар салааны бие бүрэлдэхүүн хоорондоо харилцах, командыг хүлээн авах, бай заах, гэрэл зураг, дүрсийг командын байрт дамжуулах

боломжтой. Мөн иж бүрдэлд нь "ГЛОНАСС" болон "GPS"-ийн тусламжтайгаар байршлын солбицлыг тодорхойлдог төхөөрөмж багтжээ.

РАТНИК-3: УМНЫЕ ЛАТЫ СОЛДАТА БУДУЩЕГО



ОХУ-ын Зэвсэгт хүчний хангалтад 2025 онд нэвтрүүлэхээр төлөвлөсөн "Ратник-3" загварын агсамж нь хээрийн нөхцөлд даалгавар биелүүлэхэд хараат бус байдлаараа давуу талтай. Энэхүү "Ратник" агсамж

нь өөрөө нэг том систем бөгөөд цагийн байдал, цаг уурын нөхцөл, бусад хүчин зүйлээс хамаарч өөрчлөгддөг 10 дэд системээс бүтдэг. Иж бүрдэлд нь галт зэвсэг, онилгооны систем, хуягт хамгаалалт, холбооны хэрэгсэл, "ГЛОНАСС" дээр

шаардлагатай тохиолдолд тагнуулын үйл ажиллагаа явуулах боломжтой юм. Энэхүү жижиг хэмжээтэй нисгэгчгүй нисэх төхөөрөмжийн хэмжээ нь автоматын магазинаас бага хэмжээтэй байх тухай мэдээлсэн байна. Тиймээс нэг

ОХУ-ЫН ГУРАВДУГААР ҮЕИЙН АГСАМЖ "РАТНИК-3" ТӨСӨЛ


суурилсан навигацийн аппарат гэх мэтчилэн 40 гаруй хэрэгсэл багтдаг.

М э р г э ж и л т н ү ү д "Ратник-3" агсамжийн иж бүрдлийг "Ирээдүйн цэрэг" гэж тодорхойлж байна. Мөн хамгаалах, дайсныг устгах, удирдлага, эрчим хүч, хангалт зэрэг бүхий л үзүүлэлт, зарчмын хувьд хөгжлийн шинэ түвшинд гарсан аж. Тус иж бүрдэл нь хамгаалалтын ашигтай талбайгаа мэдэгдэхүйц ихэсгэсний зэрэгцээ нийт жинг багасгаж чадсанаараа илүү давуу талтай.

Түүнчлэн иж бүрдэлд жижиг хэмжээтэй нисгэгчгүй нисэх төхөөрөмж суурилсулах боломжтой тухай мэдээ байна. Ингэснээр иж бүрдлийг хэрэглэж буй цэргийн алба хаагч хот, суурин газар, ой дотор нисгэгчгүй нисэх төхөөрөмжөө ашиглан байр зүйн баримжаалал хийх, шаардлагатай тохиолдолд тагнуулын үйл ажиллагаа явуулах боломжтой юм. Энэхүү жижиг хэмжээтэй нисгэгчгүй нисэх төхөөрөмжийн хэмжээ нь автоматын магазинаас бага хэмжээтэй байх тухай мэдээлсэн байна. Тиймээс нэг

цэрэг 3-4 дроныг өөртөө авч явах боломжтой юм.

Өөр нэг н э в т р ү л э х шинэчлэл нь цэргийн алба хаагчийн биеийн байдлыг цогц байдлаар дүгнэдэг цахим систем юм. Тус систем нь алба хаагчийн пульс, амьсгал, зүрхний цохилтын бичлэг, артерийн даралт зэрэг амин үзүүлэлтүүдийн талаарх мэдээлэл ц у г л у л н а . И н г э с н э э р эрсдэл бүхий аливаа нөхцөлд цаг алдалгүй анги, салбарын захирагч, эмнэлгийн мэдээлэлтэнд мэдээллийг шуурхай дамжуулах боломжтой



болж, шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлэх аж.

Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид нь НҮБ-ын мандаттай энхийг сахиулах ажиллагаанд болон олон улсын цэргийн ажиллагаанд идэвхтэй оролцож, цагийн байдлын хүндрүүлсэн нөхцөлд үүрэг гүйцэтгэдэг. Иймээс цэргийн алба хаагчдынхаа аюулгүй байдлыг хангах асуудал нь нэн чухал болоод байна. Зэвсэгт хүчнийг бүхэлд нь хангаж чадахгүй ч тусгай үүргийн анги, салбарын холбогдох бие бүрэлдэхүүнийг зохих стандарт, шаардлагад нийцэхүйц агсамжаар, ялангуяа хувцас, хэрэгслээр хангах нь чухал юм. Энэ талаар судалгаа хийж зохих шийдвэр гаргах шаардлага тавигдаж байна.

Цэргийн агсамжийг хийх төслийг хэрэгжүүлэхэд манлайлан оролцох нь "Бөртө" төрийн өмчит үйлдвэрийн газрын хэтийн зорилго байх болно.

Хурандаа Б.ЭРХЭМБЯАР

Ч.Цэрэндагва: ХҮМҮҮС МИНИЙ ХАРЦНААС СҮРДДЭГ БАЙСАН

Монгол Улсын Зэвсэгт хүчний түүхэнд байгаагүй том хээрийн сургуулийг гардан командалж, Үндсэн хуульдаа Зэвсэгт хүчинтэй байх тухай маш чухал заалтыг оруулан батлалцаж явсан чөлөөнд байгаа хошууч генерал Чулууны ЦЭРЭНДАГВАТАЙ ярилцсанаа уншигч танд хүргэж байна. Дашрамд түүний командалсан 5 дугаар дивиз байгуулагдсаны 100 жилийн ой ирэх онд тохиох юм.

цуваагаар авч явахад маршийн хөдөлгөөний аюулгүй байдал, сахилга батаас эхлээд хариуцлага тун өндөр байсан биз ...

-Тэгэлгүй яах вэ. Ер нь тэр үед манай армийн цэргүүд шат шатандаа хариуцлагыг дээд зэргээр мөрддөг байсан. "Зоргол-87" сургуулийн үеэр гэхэд нэг нөхөр майхан шатаасан хэрэг гарч байснаас өөрөөр сахилга, бат зөрчсөн асуудал огт байгаагүй. Маршийн үед гэвэл нэг алба хаагч үүргэлж яваад чирч явсан бууны араас орсон хэрэг гарснаас өөр зүйл байгаагүй.

За тэгээд нүүгээд очдог. Бүхэл бүтэн дивиз хүч төвхнөнө гэдэг их ажил байсан нь ойлгомжтой ...

-Нүүж очоод дивизийг байрлуулах, өвөлд бэлдэх гэсэн том ажилтай нүүр тулсан. Байдал хүнд байлаа. Орос цэргийн ангиас үлдсэн 100 гаруй барилга, байгууламж, объектыг хүлээн авч, анги, салбаруудад хуваарилан өгч, тохижилт, засварын ажлыг явуулсан. Дулаалга, сантехникийн асуудал хамгийн хүнд байв. Манай анги, салбаруудын алба хаагчид болоод Барилгын цэргийн ангиудын хүчээр намаржингаа байраа бэлдсэний хүчинд өнтэй өвөлжиж чадсан. Дивиз байрласнаас хойш офицер, ахлагч нарын хүүхдүүдийн

бие тэр үед Зэвсэгт хүчний тухай хуулиудаас гадна Хил, Дотоодын цэрэг, Цагдаа гээд бусад хүчний байгууллагуудад харьяалагдах хуулиудыг боловсруулж, батлуулсан. 1990 он улс орон даяар ардчиллын салхи сэвэлзсэн тун ч эгзэгтэй цаг үе байсан. Тэр үед зарим улс төрчид манай улсад армийн хэрэг байхгүй гэж үзэж байлаа. Харин бидний хэдэн нөхөд зүтгэсээр байгаад Үндсэн хуульдаа Зэвсэгт хүчинтэй байна гэж оруулж чадсан. Ерөнхийдөө шилжилтийн нийгмийн үеийн бүх хуулийг Бага хурлын гишүүд боловсруулсан. Ингээд Үндсэн хуулиа батлуулаад Улсын Их Хурлыг байгуулаад хуулийнхаа дагуу сонгуулийг явуулсан ба Улсын Их Хурлыг бүрдүүлээд Бага хурлын гишүүд тарсан юм. Би хугацаанаасаа хоёр жилийн өмнө чөлөөлөгдсөн.

Ягаад хугацаанаасаа өмнө улс төрийн тавцангаас буусан юм бэ, үргэлжлүүлэе гэсэн бодол танд байгаагүй юм уу?

-Тийм бодол байгаагүй. Харин ч бүр залхаад гарсан шүү. Цэргийн хүн учир цэрэг рүүгээ л татагдаад байсан. Тэгээд ч миний чаддаг, мэддэг ажил, байх ёстой газар бол Зэвсэгт хүчин шүү дээ. Би тийм газар л ажиллахаар бэлтгэгдсэн хүн. Гэхдээ улс төрөөр нэлээд өвчилчихсэн, "халдвар"

л өчнөөн бензин, шатахуун, бараа авдаг байлаа. Орос дэлгүүрээр үйлчлүүлнэ. Ер нь Оросын цэргийн ангиуд ил, далд хэлбэрээр манай ард түмнийг их тэжээсэн дээ. Үүнийг одоо цагийн залуус сайн мэдэхгүй байх.

Таны ажил албаа явуулдаг байсан ажлын онцлог, арга барилаас сонирхье ...

-Доод шатны хүмүүсээ айхтар аашилж, загнадаггүй байсан. Ерөнхийдөө өөрийнхөө сүр бараагаар ажлаа явуулна шүү дээ. Залуу байхад хүмүүс миний харцнаас их сүрддэг байсан гэж ярих юм билээ. Үнэн ч байж мэднэ. За тэгээд цэргийн дарга хүн чинь албанаасаа гадна хүмүүсийн амьдралыг мэдэрх нь чухал. Өөрөөр хэлбэл, хүмүүсийнхээ жаргалд нь тал, зовлонд нь бүтэн хамт байх хэрэгтэй. Арван хурим, найр боллоо гэхэд ядаж гуравт нь очоод баяр хүргэчих. Харин 10 хүнд зовлон тохиолоо гэвэл 10-ууланд нь очих. Өөрийн мэдлийн жаахан нүүрс, модоор хангаж, хамт олноо ч тусалж, дэмжих ажилд нь идэвхтэй оролцуулах хэрэгтэй. Цэргийн дарга хүнийхээ төлөө зүтгэж байж албаа сайжруулдаг юм шүү дээ. Зовсон цагт нь нөхөр болчихвол дараа нь тэр хүн бодно шүү дээ "Миний дарга надад тэгж тусалж байхад би



Та манай уншигчдад өөрийгөө танилцуулна уу?

-Би Өвөрхангай аймгийн Бүрд сумын уугуул. 1955 онд гуравдугаар ангиа төгсчөөд Улаанбаатар хотод ирж, 11 дүгээр сургуулийг дүүргэсэн. 1962 онд Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн механикжуулалтын ангид орсон боловч тухайн жилдээ хүнд өвдсөн тул нэг жилийн чөлөө авсан юм. Би ижийтэйгээ хоёулхнаа өссөн хүн. Ээж маань сургуульд цэвэрлэгч хийдэг. Амьдрал сайнгүй байсан учир би тухайн жилдээ Төв цахилгаан станцад ажил хийхээр шийдлээ. Ингээд ажиллаж байтал хавар цэрэг татлага болов. Би ч дотроо ер нь болж өгвөл явчих санаатай байсан. Тэр үед цахилгаан станцын ажилчид Сайд нарын Зөвлөлийн шийдвэрийн бичгээр цэрэг татлагаас чөлөөлөгддөг байлаа. Харин би тэрхүү бичгийг нь цэрэг татлагын комиссынхоо нуугаад яваад орчихлоо. Тэгээд МАА-ийн 019 дүгээр анги (одоогийн Зэвсэгт хүчний 120 дугаар анги)-д хуваарилагдаад хоёр жил долоон сарын хугацаанд байлдагчаас ахлах түрүүч цолтойгоор алба хаасан. Халагдаад 1966 оны 7 дугаар сард бага дэслэгч цолтой офицер болж артиллерийн удирдах салааны даргаар томилогдсон. 1967 онд артиллерийн танк эсэргүүцэх дивизион нэртэйгээр 120 дугаар ангийг анх байгуулагдахад нь тэнд батарейны захирагчаар дэслэгч цолтой ажлын гараагаа эхэлж, улмаар 1970-1972 онд 019 дүгээр ангидаа штабын орлогчоор ажилласан. Ингээд 1972 онд ЗХУ-ын Артиллерийн академид суралцаж, 1976 онд төгсөж ирсэн ба Ардын Армийн 120 дугаар ангийн штабын дарга, 1978-1979 онд БХЯ-ны 15 дугаар хэлтэст ахлах офицер, 1979-1983 онд Ерөнхий цэргийн 5 дугаар армийн артиллерийн командлагч, 1983-1984 онд БХЯ-ны 15 дугаар газрын даргаар ажилласан. Дараа нь 1984-1986 онд ЗХУ-ын ЗХЖШ-ын академид суралцаж төгсөөд 1986-1990 онд Монголын Ардын Армийн 256 дугаар нэгтгэлийн захирагчаар томилогдож ажилласан. Энэ хугацаанд 1988 онд ЗХУ-ын ЗХЖШ-ын академийн дээд курст суралцах боломж олдсон юм. Мөн 1987 онд "Зоргол-87" хээрийн сургуулийг зохион байгуулах хүндхэн даалгавартай нүүр тулж байлаа.

Энэ сургуулийн талаар товч танилцуулна уу, үр дүн нь юу байсан бэ?

-Тухайн үед манай армид дивизүүд байсан ч бүгд хураангуй хэлбэрээр зохион байгуулагдсан байв. Тиймээс дивизийн гол хэсгийг бүрдүүлэгч нөөцийг улс, ардын аж ахуйгаас татан оролцуулсан. Энэ үед дайчилгаанд байгаа нөөц бүрэлдэхүүнээ дадлагажуулах, сургах, хэрэгцээтэй цаг үед дивизийг хэрхэн дэлгэн зохион

байгуулах, бүх шатны дарга, цэргүүдийн үйл ажиллагааг жигдрүүлэх гэсэн хэд хэдэн том зорилготой сургууль явагдсан юм. Дивизийн дайчилгаатай хээрийн сургуулийг явуулах бэлтгэл ажлыг 1986 оны 10 дугаар сараас эхлэн шат дараатай зохион байгуулж, 1987 оны 5 дугаар сарын 24-нөөс 6 дугаар сарын 4-ний өдөр хүртэл явуулсан. Миний бие дивизийн захирагчаар оролцсон бөгөөд улс, ардын аж ахуйгаас олон зуун офицер, ахлагч, түрүүч, байлдагч, олон арван техник мөн Барилгын цэргээс олон тооны офицер, ахлагч, түрүүч, байлдагч нар уг сургуульд оролцсон юм. Ерөнхийдөө өргөн зурваст олон зуун цэргийн алба хаагчдыг, техниктэй нь дэлгэцхээд удирдлагаар хангана гэдэг нь тун амаргүй байлаа. "Зоргол-87" бол Зэвсэгт хүчний цаашдын хөгжил, байнгын бэлэн байдлыг дээшлүүлэхэд томоохон хөрөнгө оруулсан өндөр ач холбогдолтой сургууль байсан юм. Тус сургуулийг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга Д.Содном, тухайн үеийн нам, төрийн бусад удирдагчид, Батлан хамгаалах яамны сайд, хурандаа генерал Ж.Ёндон тэргүүтэй генерал, офицерууд өндөрөөр үнэлж байсан нь саяхан мэт санагдаж байна.

Мэдээж дивизийг бүрэн дэлгэж, сургуулийг амжилттай явуулахад бэрхшээлтэй зүйл олон таарсан байх ...

-Ар тал, хангалтын асуудал маш чухал байсан. Ялангуяа сургуулийг явуулах бэлтгэл ажлыг хангахад олон хүний хүч хөдөлмөрийг шаардсан. Тэр дундаа сургуульд оролцуулах зэвсэг, техникээ бэлтгэх, татах ажилд гол анхаарлаа хандуулж байлаа. Нөгөөтэйгүүр малчин, барилгачин, мужаан эсвэл тодорхой эрхэлсэн ажилгүй хэн нэгийг дайчилгаагаар татаад данслагдсан албан тушаал дээр нь дадлагажуулан гэдэг үнэхээр амаргүй байсан.

Холын марш үйлдсэн гэдэг байх аа ...

-Сургуулийн үеэр тийм марш үйлдээгүй. Харин "Зоргол-87"-оос сар гаруй хугацааны дараа буюу Батлан хамгаалах яамны сайдын 7 дугаар сарын 14-ний өдрийн тушаалаар 5 дугаар мотобуудлагын дивизийг Төв аймгийн Зуунмодоос Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын "Их уул" цэргийн хүрээнд шилжүүлэн байрлуулах шийдвэр гарч, 7 дугаар сарын 28-ны өдрөөс гурван цуваа болгон зохион байгуулсан юм. Тодруулбал, нэгдүгээр цуваанд жижиг анги, салбарууд, дараагийнхад нь артиллери, зенит, танкийн анги, салбарууд, гуравдугаар цуваанд мотобуудлагын анги, салбарууд марш үйлдэж, Арвайхээр хотын нутагт байрлаж байсан Зөвлөлтийн цэргийн ангийн хотхонд шилжин очиж байлаа.

Тийм их хүч, техникийг



Ч.Цэрэндагва ЗХУ-д суралцаж байхдаа эхнэр, дүүгийн хамт. 1884 он, Москва хот.

сургууль, цэцэрлэгүүд байгуулагдаж, аймгийн хөгжилд ч дорвитой хувь нэмэр оруулж эхэлсэн. Хоёрхон жилийн дараа гэхэд дивиз маань ногооны талбай, хүлэмж, 3000 малтай болж, гахай, тахианы гээд туслах аж ахуйг сайн хөгжүүлсэн. Тухайн үед надтай хамт ажиллаж байсан журмын нөхөд маань анги, салбарынхаа орчин нөхцөлд ам сайтай байдаг байлаа.

Тухайн үед дивизийн штабын дарга нь хурандаа Баттулга, улс төрийн хэлтсийн дарга Жанцан, дараа нь Тогоо генерал, Ар талын орлогч нь Цагаац, техникийн орлогч Тогтох гээд сайхан хурандаа нар байлаа.

Таныг улс төрд байсан гэж сонссон юм байна. Энэ тухайгаа ярина уу?

-1990 онд "Их уул" цэргийн хүрээнээс манай хорооны захирагч, хурандаа Б.Цэрэнчимэд бид хоёр сонгуульд өрсөлдөөд Ардын Их Хурлын депутатаар сонгогдсон. Тэгээд Ардын Их Хурлын чуулганаар Улсын Бага Хурлын гишүүн болж, хоёр жил гаруй улс төрийн албанд зүтгэсэн. Тэрхүү Бага хурлын гишүүд анхны ардчилсан Үндсэн хуулийг боловсруулахад нойр, хоолгүй зүтгэсэн дээ. Мгний

авчихсан хүн армидаа ирж байлаа шүү. Бага хурлын гишүүнээсээ буугаад Р.Болд даргатай Стратегийн судлалын хүрээлэнд ажилласан. Сар гаруй ажиллаад генерал цол хүртэж 1993 онд Зүүнбаянгийн дивизийн захирагчаар томилогдсон. Тэнд хоёр жил захирагчаар ажилласан ба 1995-1996 онд Зэвсэгт хүчний Ерөнхий штабын орлогчоор ажиллаж байгаад гавьяаныхаа амралтад гарсан. Түүнээс хойш олон ажил хийжээ. Төрийн бус байгууллага ч байгуулж үзлээ. Дашрамд, би Монгол Улсын Зэвсэгт хүчинд бүрэн хэмжээний хоёр дивизийг командалсан цорын ганц хүн юм билээ.

Та хойд хөршийн ард түмнээс хамгийн чухалд тооцогдох чухам юуг нь сурч, мэдсэн бэ?

-Тухайн үед монголчуудыг малчны хотноос нь "вагон вагон"-оор нь хойшоо сургаж, Европ дахины боловсролыг эзэмшүүлж, сэхээтний бүхэл бүтэн давхаргыг бий болгож байлаа шүү дээ. Ер нь бүгд л Оросын ард түмнээс суралцсан. Мань мэтийн сураад ирсэн хүмүүсээс гадна зүгээр энд амьдарч байсан нь ч тэднээс их зүйлийг сурсан. Оросын арми манай улсад байрлаж байх үед монголчууд очиж уулзаад

ядаж хариуцсан ажлаа сайн хийгээд итгэлийг нь алдахгүй явчих юм сан" гэж. Ингэж бодсон цэрэг хэзээ ч албандаа сэтгэл хоёрдохгүй бөгөөд аяндаа өөрийнхөө ажилдаа сэтгэлээ шингээгээд эхэлнэ. Мөн захиргаандаа байгаа албан тушаалтнуудаа үнэн, зөвөөр нь дүгнэх нь маш чухал.

Өнөөдрийн Зэвсэгт хүчний талаарх таны бодол ...

-Хэдий тэтгэврийн хөгшин ч гэсэн Зэвсэгт хүчнийхээ талаар байнга чих тавьж, чагнаж байдаг юм. Яах вэ, болж бүтэж байгаа ч юм байна, зарим талаараа шүүмжлэлтэй хандмаар ч юм байна. Гэхдээ аливаа үйл ажиллагаа цаг цагаараа байдаг шүү дээ. Би магтлаа, мууллаа гээд яах ч юм. Ер нь манай Зэвсэгт хүчин үүрэг гүйцэтгэлт талаасаа цаг үетэйгээ хөл нийлүүлж байна гэж боддог. Сүүлийн жилүүдэд Батлан хамгаалахын хууль, эрх зүйн баримт бичгүүдээ цэгцлээд авлаа. Гэхдээ эх орноо хамгаалж байгаа цэргийн алба хаагчдынхаа нийгмийн асуудал, ахуй талыг нь төр, засгаас арай илүү анхаармаар юм шиг санагддаг.

Ярилцсанд баярлалаа. Танд эрүүл энхийг хүсье.

Ахлах дэслэгч М.МӨНХЗОРИГ


ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНЫ ЯЛАЛТЫН 75 ЖИЛИЙН ОЙД

Чөлөөлөх дайны ялалтын 30 жилийн ойг тохиолдуулан дайнд оролцсон ахмад дайчдын дурдатгалуудыг эмхэтгэн хоёр ботийг хэвлүүлэхээр бэлтгэсэн боловч тухайн үед нэг ботийг нь хэвлүүлсэн ба хоёр дахь боть нь хэвлэгдээгүй өнөөг хүрчээ. Тус ботид хэвлүүлэхээр бэлтгэсэн 73 улс төрийн ажилтны дурдатгалаас Чөлөөлөх дайны ялалтын 75 жилийн ойг тохиолдуулан “Соёмбо” сонины редакц, Батлан хамгаалахын төв архив хамтран ямар нэгэн нэмэлт хасалтгүй, цувралаар нийтлүүлж, судалгаа, лавлагаа, мэдээллийн эргэлтэд оруулан нийтийн хүртээл болгож байна.

Наранбулаг, Молцог элс, Овоо хийдийн районд шилжүүлэн байрлуулах ажлыг удирдах; -цэргийн анги, салбаруудыг байлдаанд бэлэн байлгах явдлыг хангах; -холбогдох нөөц, хэрэглээг нэгтгэл, ангиудыг хангах зэрэг асуудал байв. Энэ өдрүүдэд хээрийн штабын ажил тун их байлаа. Гэвч давшилтад орох хугацааны тухай тодорхой ярилцаагүй байв. Энэ тухай цөөн хэдэн хүн л мэдэж байсан биз ээ. Байлдааны бүх бэлтгэл ажил маш нууц хийгдэж байлаа. Манай ангиудыг байлдаанд бэлтгэх ажилд командлагч биечлэн анхаарч, холбогдох бүхий л арга хэмжээг авч, бүх дайчдад зориулан үзүүлэх сургуулийг хэд хэдэн удаа хийлгэсэн юм. Тактикийн сургуулийн явцыг командлагч өдөр тутам байнга сонирхож,

болох нийтийн дайсан Японы империализмын эсрэг дайны зорилго, гүйцэтгэх үүргийнхээ тухай байлдагч бүр сайн мэдсэн байхыг уриалж байлаа.

1945 оны 8 дугаар сарын 8-ны шөнө чимээ анир ч үгүй, цаг мөч өнгөрсөөр л байв. Бид сэтгэл догдлон байн байн бие биеэсээ цаг хэд бэлтгэж байгааг асууцгаана. Цэргүүд ч команд хүлээж, морьдынхоо дэргэд зогсоцгооно. Ямар их гавьяат үйлс тэдний өмнө хүлээж байгааг тэд бүрэн ухамсарлажээ. Ашгүй хүсэн хүлээж байсан цаг ирлээ. Анир чимээгүй, нам гүм байдал агт морьд, хүмүүсийн хөдөлгөөний чимээ, машин, техникийн моторын нүргээний дуугаар солигдов. Давшилт эхэллээ. Наймдугаар сарын 9-ний үүрээр Монгол-Зөвлөлтийн цэргүүд нэгэн зэрэг БНМАУ-ын хилийг давлаа.



ЛУВСАНДОРЖИЙН ТОЙВ

Төр, нийгэм, цэргийн зүтгэлтэн. Баянхонгор аймгийн Элзийт сумын 7 дугаар багийн харьяат. 1915 онд төрсөн. Хурандаа цолтой.

1934 оноос Завхан аймгийн дунд сургуулийн түүхийн багш, Өвөрхангай аймгийн Уянга сумын сургуулийн захирал, мөн аймгийн Гэгээрлийн хэлтсийн дарга, Хувьсгалт залуучуудын эвлэлийн Төв хорооны сонин эрхлэгч, Өвөрхангай аймгийн ХЗЭ-ийн хорооны нарийн бичгийн даргаар ажиллаж байгаад 1938 оны 3 дугаар сарын 28-ны өдөр цэргийн албанд ирж “Улаан од” сонин эрхлэгч, 1940 оноос ЗХУ-д Улс төрийн академид сонсогч, 1942 оноос “Улаан од” сонин эрхлэгч, 1943 оноос Улс төрийн газрын суртлын хэлтсийн даргаар алба хаасан. 1947 онд Намын Төв хорооны шийдвэрээр цэргийн албанаас бэлтгэлээр халагдаж, МАХН-ын Төв хороонд хэлтсийн эрхлэгч, Монголын зохиолчдын хорооны дарга, ЗХУ, БНХАУ-д Элчин сайдын яаманд зөвлөх, ГЯЯ-нд хэлтсийн дарга, ЗСБНХУ-ын ГЯЯ-ны дипломатын академийн сонсогч, НУБ-ын дэргэд суугаа байнгын төлөөлөгч, ГЯЯ-ны нэгдүгээр орлогч сайд, 1968-1970 онд мөн яамны сайдаар ажиллаж байсан. Тэрээр 1945 оны Чөлөөлөх дайнд МАХЦ-ийн Улс төрийн газрын Суртал ухуулын хэлтсийн даргаар үүрэг гүйцэтгэн оролцож, үүрэг сайн биелүүлсэн учир Байлдааны гавьяаны улаан тугийн одон, Монгол, Зөвлөлтийн “Бид ялав” медалиар шагнагдсан.

ДОЛОННУУРЫГ ЧӨЛӨӨЛСӨН НЬ

Түүхт үйл явдлаас хойш олон жил өнгөрч их зүйл мартагдсан боловч би хувийнхаа тэмдэглэлд тулгуурлан 1945 оны байлдааны өдрүүдэд фронт дээр тохиолдож байсан үйл явдлуудын тухай бичье.

1945 оны 7 дугаар сар, монгол нутгийн нарлаг сайхан зуны өдрүүдэд налгар өргөн тал, гүн цэнхэр огторгуй, ургамал, цэцгийн анхилуун сайхан үнэр зүрх сэтгэлийн амгалан тайвныг илтгэнэ. Ийм нэгэн өдөр Ардын Армийн Улс төрийн газрын орлогч дарга, генерал С.Равдан, Жанжин штабын дарга, генерал Д.Дамдинхүү, их бууны командлагч, генерал Г.Эрэндоо нар болон Монголын Ардын Армийн Жанжин штабын хэсэг дарга нар манай армийн морьт цэргийн ангиудыг шилжүүлэн байрлуулахаар Байшинтад очсон юм.

Эдгээр нөхдийн хамт би ч мөн очсон. Биднийг очсоноос хойш хэд хоногийн дараа 17-ны бил үү, 18-ны бил үү, сайн санахгүй байна, нэгэн өдрийн орой, харанхуй болж байх үеэр манай хилийн зүгээс хэд хэдэн хөнгөн тэрэг хүрч ирлээ. Эдгээр машинаар Зөвлөлтийн армийн 30 орчим генерал, офицер ирсэн юм. Тэд янз бүрийн насны хүмүүс байсан бөгөөд цөм ногоон комбинзон өмссөн байлаа. Тэдний нэг нь хамгийн түрүүнд машинаас бууж, бидэнд мэндлээд, өөрийгөө хурандаа генерал Морозов гэж танилцууллаа. Хожим дуулах нь ээ, энэ хүн хурандаа генерал Морозов биш, харин Зөвлөлт Холбоот Улсын маршал Р.Я.Малиновский байсан ажээ.

Хэдийгээр маршал Р.Я.Малиновский тэнд ганцхан хоноод явсан боловч манай армийн төлөөлөгчдийг хүлээн авч, уулзаж амжсан юм. Уулзалтын үеэр маршалд армийн дайчдын улс төр-санал сэтгэлийн байдлын тухай генерал С.Равдан, цэргийн ангиудыг хэрхэн байгуулж байгаа тухай генерал Д.Дамдинхүү, түүнчлэн байлдааны хэрэгслийн тухай генерал Г.Эрэндоо нар илтгэснийг би хожим генерал Д.Дамдинхүүгээс сонссон. Үүнээс хойш энх тайван цагт нөхөр Малиновскийтай олон удаа нүүр тулж учирсан бөгөөд олон жилийн өмнө манай хилийн дэргэд болсон энэ мартагдашгүй уулзалтыг байнга дурсан санадаг билээ.

1945 оны 7 дугаар сарын 17-ны үеэр Зөвлөлтийн армийн генерал И.А.Плиев хүрэлцэн ирлээ. Энэ хүн удалгүй Монгол-Зөвлөлтийн морьт-механикжуулсан группийн командлагчаар томилогдсон юм. Командлагчийг хүрэлцэн ирснээс хойш төдий л удалгүй Монгол ардын хувьсгалт армийн хэргийн штаб байгуулагдсан бөгөөд даргаар нь генерал Д.Дамдинхүү томилогдов. Хээрийн штабын үндсэн зорилгууд нь:

-МАХЦ-ийн нэгтгэл, ангиудыг

өөрөө үргэлж оролцдог байв. Наймдугаар сарын эхээр байлдааны шуурхай бэлтгэлийн ажиллагаа дуусах тийшээ хандаж, байлдаанд бэлтгэх талаар ангиудад хийгдсэн ажлын дүнг гаргах болов.

Байлдааны бэлтгэлийн шалгалт Монголын морьт дивизүүдээс эхэлсэн юм. Командлагчаас юуны өмнө Монголын Ардын Армийн бүх дайчид орчин үеийн дайны туршлагыг эзэмших, энэ талаар тэдэнд тусламж, дэмжлэг үзүүлэхийн чухалд маш их анхаардаг байв. Үнэндээ ч бидэнд Гитлерийн Германы эсрэг Зөвлөлтийн ард түмний Агуу их Эх орны дайны ялалтын туршлагыг судлан эзэмших явдал чухал байлаа. Энэ нь манай армийн шаардлагад бүрэн нийцэж байсан юм.

Шалгалтын үед командлагч ялангуяа цэрэг нэг бүрийн болон жижиг салбаруудын бэлтгэлд онц анхаарч, “Мориор өдөрт хэдэн километр явж чадах вэ?, Хэчнээн сум, хэдий хэр байлдааны хэрэгслийг биедээ авч явж чадах вэ?, Сэтгэл санаа ямар байна, байлдаанд ороход бэлэн үү?” гэх зэргээр үргэлж асуудаг байв. Эдгээр асуултад өгсөн хариуг сонсоод командлагч “Монголын армийн үндсэн гол сайн чанар нь бүх дайчдын ухамсар өндөр, морьт цэргүүдийн хүнд нөхцөлд хурдан давших бололцоо илт байна” гэдэг дүгнэлтийг хийсэн байв.

Байлдааны өвөрмөц онцлог байдлыг харгалзан нэгтгэлийн дарга нарт командлагчаас дор дурдсан зөвлөгөөг өгсөн. Үүнд:

-Анги, салбаруудын хөдөлгөөнийг хөнгөвчилж, идэвхжүүлэх зорилгоор, түүнчлэн Японы талаас химийн зэвсэг хэрэглэхгүй нь илтэд байсныг харгалзан морьт ангиудын дайчдын хорт утааны багийг ар талын анги, салбаруудад үлдээж;

-аль болохоор их хэмжээний сум, байлдааны хэрэгслийг авч хоол, хүнсний зүйлийг бага авах;

-давшиж байгаа ангиудыг шаардагдах байлдааны хэрэгслээр цаг тухайд нь тасралтгүй хангах;

-хурдавчилсан маршийн шаардлагад тохируулан агт морьдыг хайрлан хамгаалах зорилгоор бүх морьдыг тахлах.

Товчхондоо иймэрхүү гол зөвлөгөөг командлагч манай ангиудын байлдааны бэлтгэлийг шалгаж үзсэний дараа бидэнд өгсөн юм. Командлагчийн өгсөн эдгээр зөвлөгөө нь байлдах районы бодит нөхцөлийг яах аргагүй сайн мэдэж байгаад тулгуурласан нь илт байлаа. Командлагчаас байлдааны бэлтгэлийг ингэж биечлэн шалгасан явдал нь байлдаанд амжилттай бэлтгэхэд их тус болсон билээ.

Наймдугаар сарын 8-ны орой бүх ангиудад цуглаан болж, улс төрийн ажилтнууд товч үг хэлсэн юм. Тэд хэлсэн үгэндээ дэлхийн хоёрдугаар дайны эцсийн голомт

Ерөнхий командлагчийн орлогч бөгөөд Монголын Ардын Армийн Улс төрийн газрын дарга Ю.Цэдэнбал давшилт эхлэхээс өмнө болон давшилтын үеэр нам, улс төрийн ажлыг удирдуулах зорилгоор Улс төрийн газрын хариуцлагатай ажилтнуудыг нэгтгэл, ангиудаар хуваарилсан нь давшилтын цаашдын үйл ажиллагаанд сайн нөлөө үзүүлсэн юм. Давшилтын өмнөхөн би 6 дугаар морьт дивизэд томилогдов, энэ дивизийнхээ хамтаар улсын хилийг давсан юм. Тус дивизийн дарга нь миний хэдийн танил хурандаа М.Цэрэндаш байлаа. М.Цэрэндаш бол туршлагатай дарга, сайн нөхөр билээ. Тэр маш энгийн бөгөөд сайхан сэтгэлтэй хүн. Гэсэн ч энэ нь түүний шударга бөгөөд шаардлагатай дарга байхад нь хэзээ ч саад болдоггүй байлаа. Тус дивиз Халхын голын байлдаанаас эхлэн олон баатарлаг гавьяаг байгуулсан дайчин түүхтэй. Дивизийн гал улаан туганд Байлдааны гавьяаны одон үүрд гялалзана. Ийм дивизийн хамт давших нь надад их нэр төрийн хэрэг байлаа. Одоо санахад, хил давсны маргааш манай дивиз дээр нөхөр Ю.Цэдэнбал хүрэлцэн ирсэн юм. Давшилтын эхэн үед түүний хүрэлцэн ирсэн явдал нь бидэнд баяр бахдалыг төрүүлж байв. Тэрээр давшилтын анхны өдрийн байдалтай тодорхой танилцсаны дараа дивизийн командлалын өмнө хэд хэдэн тодорхой зорилгыг тавилаа. Тухайлбал, ангиудад явуулах улс төр, хүмүүжлийн ажлыг сайжруулах, нутгийн ард түмэнтэй зөв харилцаа тогтоох, давшиж байгаа ангиудыг хүнсний болон байлдааны хэрэглээг эрс шуурхай хангахыг онцолсон юм.

Монголын хилээс Их Хянганыг хүртэлх асар хол зайг бид ахар богино хугацаанд туулах ёстой байлаа. Чухам үүнээс манай амжилт шалтгаалах байв. Товчоор хэлбэл, дайсны бодож, хүлээгээгүй газарт нь гэнэтийн, шуурхай цохилт өгөхөд манай зорилго оршиж байлаа. Энэхүү зорилгыг биелүүлэхэд хурдан бөгөөд шуурхай давших явдал нь чухал ач холбогдолтой. Гэвч манай давшилт байгаль, газар зүйн онцлогоос шалтгаалан хүндэрч байлаа. Замд нүд алдам усгүй уудам тал, элсэн манхан цөл, эгц цавчим хадтай шовх шовх уулс, түргэн урсгалт, их устай уулын голууд элбэг тохиолдоно. Дээрээс нар шарж, доороос элс төөнөж, тэсэхийн аргагүй халуунд хүмүүс, морьд ангаж цангаж байв. Энэ л хүнд саад бэрхшээлийг үл хайхран найрамдалт хоёр орны зоригт дайчид өдөр, шөнөгүй шуурхайлан давшаар байв. Төр, засгийнхаа уриалгад зоригжсон Монголын морьт цэргүүд саад бэрхшээлийг тэсвэр хатуужилтайгаар даван туулж, хоногт 80-120 километр урагшилж байлаа.

Хурдавчилсан маршийн ачаар

манай дивиз хэдхэн хоногийн дотор Ар Цагаан нуурын районд хүрсэн юм. Цаашлах тусам зам улам бэрх болсоор л. Удалгүй бид элсэн манханд тулав. Шөнийн харанхуй давшиж байх үеэр ганц нэг буун дуу гарах явдал олширлоо. Энэ нь манай ангиудын давшилтыг саатуулах зорилгоор япончуудын үлдээсэн хорлон сүйтгэгч бүлгүүдийн ажиллагаа байлаа. Элсэн манхныг гаталж явахдаа манай байлдагчид хорлон сүйтгэгчдээс маш их сэрэмжлэн болгоомжилж явсан билээ. Бусад зорилгоосоо гадна худаг, усыг хордуулах даалгавартай энэхүү хорлон сүйтгэгч бүлгүүдийн ажиллагааг анхааралгүй орхиж болохгүй байсан нь мэдээжийн хэрэг.

Ихэд цангасан байлдагчдыг хордсон худгийн уснаас уулгахгүй байлгахын тулд үргэлж сэрэмжтэй явах хэрэгтэй байв. Ялангуяа элсэн манхныг давж туулах нь дугуйт хөсөг ба их буунуудтай явахад маш хүнд байлаа. Гэвч манай байлдагчид туйлдсан морьдоо арчилж, элсэнд суусан тэрэг болон их буунуудаа татаж гарган давшаар л байлаа. Дараа нь өдөр, шөнөгүй ширүүн бороо цутгаж, бас нэгэн бэрхшээл нэмэгдэв. Үүний улмаас хангамжийн асуудал тулгарч, байлдааны хэрэглэл ба хүнсний зүйлийг татах олигтой замгүйгээс болж хөсөг тээвэр ба шатахуун дутагдаж эхлэв. Энэ үед ар талын албаны бүх хүмүүс хүч хөдөлмөрөө дайчлан идэвх зүтгэл, зориг самбаатай ажиллаж өөрсдийн өмнө тавигдсан үүргээ биелүүлсэн юм. Энэ өдрүүдэд Ю.Цэдэнбал давшиж байгаа ангиудтай үргэлж хамт явж, ар талын албаны ажиллагаатай өдөр бүр танилцан тодорхой заавар өгдөг байлаа. Жишээлбэл, нэгэн удаа нөхөр Ю.Цэдэнбал анги, салбараасаа хоцорсон цэргүүдэд хоол ундаа хийхэд нь зориулж аяны тогоонуудыг замын дагуу нэг хэмжээний зайд үлдээх тухай

даалгаврыг бидний хэсэг улс төрийн ажилтнуудад өгсөн юм. Энгийн цэргүүдийг ингэж анхаарч, халамжилж байсан нь бидний хайр, хүндэтгэлийг төрүүлж байлаа. Мөн тэрээр нам, улс төрийн ажлыг зөвхөн хурал, цуглааны хэлбэрээр биш хөдөлгөөн дунд болон амралтын үеийг ашиглан хийж байх тухай анхааруулж, улс төрийн ажилтан бүр байлдагчдын санал сэтгэл, хүсэл мөрөөдлийг сайн мэдсэн байх ёстой гэж шаарддаг байв.

Элсэн манхан дундуур 300 гаруй километр давсаны дараа 8 дугаар сарын 14-ний өглөө Долоннуурыг эзлэн авлаа. Бидний нүднээс буддын шашны сүм хийд, хятад маягийн нэг янзын навтгар шарвар барилгуудтай эртний хот тодорлоо. Чухам энд, энэ хотод 1691 онд болсон хурлаар харийн булаан эзлэгч боолчлогчдын гинжний нохой болсон Монголын феодалууд Монголын ард түмний олон зуун жилийн хүсэл мөрөөдлийг үл тоомсорлон Манжийн булаан эзлэгчдэд ичгүүртэйгээр дагаар орсон билээ. Япончууд Өвөр Монголын нутгийг түүхийг эд, хүнсний эх булаг, БНМАУ ба ЗСБНХУ-д довтлох дайны хамгийн ойр талбар гэж үздэг байжээ.

300 шахам жилийн дараа Монголын дайчид өс хонзонгоо авахаар биш харин чөлөөлөгч гэсэн ариун үүрэгтэй очсон юм. Харийн булаан эзлэгчдээс энгийн номхон ард иргэдийг чөлөөлөх явдал энх тайван, найрамдлын үзэл санаатай Монгол-Зөвлөлтийн армийн ариун үүрэг байлаа.

Энэ л хотын иргэд улаан далбаа, дарцаг барьж Монгол-Зөвлөлтийн дайчдыг баяр баясгалантайгаар хүлээн авч билээ.

Долоннуурыг чөлөөлсний дараа бид давшилтаа үргэлжлүүлэн чөлөөлөх ариун бөгөөд шударга зорилгоо биелүүлсэн юм.



ДЭЛХИЙН ТЭРГҮҮЛЭГЧ ЗЭВСЭГТ ХҮЧНҮҮДИЙН ЦАЛИН, ХАНГАМЖ

Олон залуус эх орныхоо төлөө тангараг өргөж, цэргийн алба хаах хүсэл, сонирхолтой байдаг. Эртний Хятадын мэргэн үгэнд "Цэрэг-гэр бүлийн бахархал" гэсэн байдаг нь үүний нэг илрэл юм. Зөвхөн эх оронч хүмүүжил, төлөвшилтэйгөөс үүдэн залуус цэргийн алба хаадаг гэсэн үг биш. Олон оронд эрэгтэй хүн бүр ямар нэгэн хугацаагаар цэргийн албыг биеэр хаахаар хуульчилсан байдаг тул хүсэхгүй ч цэргийн алба хааж байгаа мянга мянган залуус бий. Гэхдээ өөрийн хүслээр цэргийн алба хааж байгаа залуусын тоо нь сая саяар тоологдох нь дамжиггүй.

Дэлхийн аль ч улсад цэргийн албыг хаавал тухайн хүнийг Засгийн газар, Зэвсэгт хүчин нь хөгжүүлж, сурган дадлагажуулах бүхэл бүтэн тогтолцоо ажиллаж байдаг. Мөн цалин, хангамжийн хувьд бусад мэргэжлийг бодоход харьцангуй өндөрт тооцогддог баталгаат ажлын байр тул залуус энэхүү албанд дуртай байдаг.

Ингээд та бүхэнд улс орнуудын цэргийн алба хаагчдын цалин, хангамжийн талаарх сонирхолтой тоо, баримтыг танилцуулъя.

АНУ
Дэлхийн хамгийн хүчирхэг эдийн засагтай АНУ нь Зэвсэгт хүчнээрээ ч мөн адил тэргүүлдэг. Батлан хамгаалахын төсөв нь ардаа жагсдаг топ есөн улсын батлан хамгаалахын зардлыг нийлүүлээд ч хүрэхгүй тийм их хөрөнгө, мөнгийг Зэвсэгт хүчинд зарцуулдаг байна. Үүнийг дагаад цэргийн алба хаагчдын цалин нь аль ч улсынхаас өндөр юм. Тухайлбал, АНУ-ын цэргийн алба хаагч сард дунджаар 4000 долларын цалин авдаг. Үүнээс гадна хилийн чанадад болон дэлхийн халуун цэгт үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн алба хаагчдад хоногт ойролцоогоор дөрвөн доллар олгодог байна. Энэхүү тоо нь тухайн гүйцэтгэж байгаа үүргийнх нь онцлогоос шалтгаалан харилцан адилгүй байх бөгөөд зарим тохиолдолд сарын цалингаас нь хэд дахин өндөр гарах ч тохиолдол байдаг. АНУ-ын хамгийн өндөр албан тушаалыг хашдаг генерал нь жилд дунджаар 150,000-200,000 ам.долларын цалин авдаг аж.

ОХУ
ОХУ эдийн засгийн хүндрэлийн улмаас цэргийн алба хаагчдынхаа тоог хэдэн арван мянгаар багасгах шийдвэрийг 10 гаруй жилийн өмнө гаргаж



байв. Гэхдээ энэ нь цэргийн алба хаагчдын цалин өсгөхөд нэлээдгүй том дэмжлэг болсон. Тухайн үед дундаж цалин нь 400-500 ам.доллаароос 800-1000 ам.доллар болж өсжээ. Мэдээж АНУ-тай харьцуулахад хэд дахин бага боловч хангамжийн хувьд хэд дахин илүү юм. Онцолбол, цэргийн сургуулийг төсөж байгаа шинэхэн офицерт эд материалын нэг удаагийн тусламж болгон нэг сарын цалин олгодог. Мөн ОХУ-ын Зэвсэгт хүчинд алба хааж байгаа цэргийн алба хаагчдыг улсаас амьдрах байраар хангах хуультай. Хэрвээ тухайн алба хаагчийг орон сууцаар хангах боломжгүй бол байр хөлслөн суух зардлыг нь төрөөс даадаг. Үүнээс гадна цэргийн жинхэнэ албыг биеэр хааж цэргийн тэтгэвэрт гарч байгаа хүнд хамгийн сүүлд алба хааж байсан орон нутагт нь ам бүл, гүйцэтгэсэн үүргийг нь харгалзан үзэж орон сууц олгодог. Үүний дагуу сүүлийн таван жилд 61000 цэргийн алба хаагчид орон сууц олгосон байна. ОХУ-ын Зэвсэгт хүчний хамгийн өндөр албан тушаалтай генерал сард 800-900 ам.долларын үндсэн цалин авдаг аж. Мэдээж үүн дээр бусад нэмэгдэл нь орно.

БНХАУ
Хятадын Ардын Чөлөөлөх Арми /ХАЧА/-ийн Хуурай замын цэргийн энгийн нэг байлдагч сар тутам 100-120 ам.долларын

цалин авдаг нь бусад дэлхийн хүчирхэг орнуудтай харьцуулахад харьцангуй багад тооцогддог. Энэ нь мэдээж цэргийн алба хаагчдын тоотой холбоотой. Гэхдээ БНХАУ-ын өндөр тушаалын цэргийн алба хаагчид болон офицерууд жилд дунджаар 30,000 ам.долларын цалин авдаг нь дэлхийн дунджаас дээгүүрт орно. Бусад орны Зэвсэгт хүчинтэй харьцуулахад Хятадын Ардын Чөлөөлөх Арми нь офицеруудынхаа ахуй хангалтад илүүтэй анхаардаг байна. Жишээлбэл, офицеруудад зориулсан орон сууцны ипотекийн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бөгөөд тус хөтөлбөрт хамрагдах боломжгүй офицеруудад цэргийн хотхонд албан тушаалын байр олгодог юм. Мөн Хятад улс нь цэргийн жинхэнэ албанаас хүндэтгэх шалтгаан, ар гэрийн гачигдлаас үүдэн халагдсан иргэдэд дараачийн амьдралаа эхлүүлэхэд нь дэмжлэг үзүүлдэг байна. Мэдээж, тус дэмжлэгийг үзүүлэхдээ тухайн хүний гүйцэтгэж байсан үүрэг, боловсрол, насыг нь харгалзан үздэг. Тухайлбал, цэргийн тэтгэвэрт гарсан хүнийг орон нутгийн удирдах байгууллагад ажилтнаар авах, залуусыг их, дээд сургуульд суралцуулдаг аж.

INOSMI.RU

ЗОГССОН ХЭЛЭЛЦЭЭР ҮРГЭЛЖИЛЛЭЭ



Дөрөвдүгээр сарын эхээр "Талибан" бүлэглэл хоригдол солилцох асуудлаар Афганистаны Засгийн газартай хийж буй хэлэлцээг зогсоож байгаагаа мэдэгдсэн. Тэдний зүгээс "Манай хоригдлуудыг суллах хугацааг ямар нэгэн шалтгаар одоог хүртэл хойшлуулсаар байна. Үүнтэй холбогдуулан манай зүгээс үр ашиггүй уулзалтуудад оролцохгүй" гэж "Талибан" бүлэглэлийн төлөөлөгч "Twitter" хуудсандаа мэдэгдээд байв.

Тэгвэл өнгөрөгч долоо хоногт Афганистан улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн төлөөлөгч Жавид Фейсал "Талибан" хөдөлгөөний 361 гишүүнийг шоронгоос

сулласан талаар өөрийн цахим хуудсаар дамжуулан мэдэгдлээ. Тэр бээр "Афганистаны Засгийн газар нь Ерөнхийлөгчийн 3 дугаар сарын 11-ний өдөр гаргасан зарлигийн дагуу "Талибан"-ы 361 хоригдлыг Баграм шоронгоос сулласан бөгөөд тус хөдөлгөөний 1500 гишүүнийг суллагдах хүртэл хоригдол солилцох ажиллагаа үргэлжилнэ" гэж бичсэн байна.

Энэхүү үйл явдалтай зэрэгцэн "Талибан" хөдөлгөөн Засгийн газрын 20 цэргийг суллаж, Кандагар мужийн Олон улсын Улаан загалмайн нийгэмлэгт шилжүүлэн өгсөн байна.

ТАСС

СУРГУУЛИЙГ КИМ ЖОН УН УДИРДАН ЯВУУЛЛАА



БНАСАУ-ын Ардын Армийн мина харвалтын нэгтгэл, ангийг оролцуулсан их бууны буудлагын төлөвлөгөөт бус сургуулийг Ким Жон Ун удирдан явууллаа гэж Солонгосын Төв цахилгаан мэдээний агентлаг мэдээлжээ. Энэхүү мэдээнд цохон тэмдэглэсэнээр, сургуулийг гэнэт зохион байгуулсан ба нэгтгэл,

ангиудын байлдааны бэлэн байдлыг шалгах зорилготой байсан аж. Мөн гэнэтийн байлдааны сургуулийг тэмцээн хэлбэрээр зохион байгуулсан байна. Энэ удаагийн сургууль нь 2020 он гарснаас хойш тус улсын их буучдын дунд зохион байгуулсан гурав дахь удаагийн сургууль юм.

РИА Новости

МӨРГӨЛДӨӨН ҮҮСЖЭЭ



Өнгөрсөн долоо хоногт Чили улсаас эх орон руугаа буцахаар Боливиын 200 орчим иргэн Кольчана хотын шалган нэвтрүүлэх цэгээр хил нэвтрэхийг оролдсон боловч Боливи улсын Ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч Жанин Аньесийн коронавирусийн халдварын тархалтыг

хязгаарлах зорилгоор хорио цээрийн дэглэмийн хүрээнд гаргасан хилээ хаах шийдвэрийн дагуу тэднийг хилийн цэргүүд оруулаагүй байна. Татгалзсан хариу авсныхаа дараа иргэд цэргүүд рүү чулуу болон эд зүйлсийг шидэж эхэлжээ. Хариуд нь цэргийн алба хаагчид нулимс

асгаруулагч хий хэрэглэжээ. Боливи улсад коронавирусийн халдварын анхны тохиолдол 3 дугаар сарын 10-ны өдөр бүртгэгдсэнээс хойш 190 гаруй хүн халдвар авч, 14 хүн нас барсан байна.

ТАСС

Шинэ зэвсэг, техник

БАЙЛДААНЫ РОБОТ-ТЕХНИКИЙН ЦОГЦОЛБОР "ПАЛАДИН"




Байлдааны робот-техникийн цогцолбор "Паладин"-ыг "Армия-2019" олон улсын зэвсэглэл, техникийн үзэсгэлэн дээр анх удаа олонд танилцуулсан бөгөөд түүний талаарх мэдээлэл одоог болтол ил болоогүй. Шинжээчдийн үзэж байгаагаар тус цогцолбор нь нэн өндөр цэцтэй байх бөгөөд 30 миллиметрийн их буу, 7.62 миллиметрийн автоматаар зэвсэглэгдэж, сүүлийн үеийн

тоон технологи бүхий мэдээлэл дамжуулах систем байх аж. Мөн их буг нь 57 миллиметрийнх болгох бүрэн боломжтой зэрэг зөвхөн таамаг төдий мэдээлэл байгаа юм. Харин ил болсон ганцхан зүйл нь байлдааны робот-техникийн цогцолбор "Паладин" нь "Явган цэргийн байлдааны машин-3"-ын явах анги дээр суурилагдсан талаар юм.

RUSARMYEXPO.RU

Нүүрийг бэлтгэсэн ахмад Э.ОЧУҮУ



Дугаарын зочин

"Nomadic Comic" буюу "Нүүдлийн зурган өгүүлэмж" компанийн ажилтан, "Хандгай продакшн"-ы ахлах С.ЖАМБАЛЦЭРЭНТЭЙ ярилцлаа. Бид түүнийг "Хандгай" хэмээх зурган өгүүлэмжийн цуврал бүтээлээр нь илүүтэй мэдэх билээ.

"Nomadic Comic" гэх айлын нэг гишүүн болно гэсэн төсөөлөл эртнээс байсан уу?

-Би есдүгээр ангиа төгсдөг жил улаан шугамын доор жагссан. Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулиас 104 дүгээр сургууль руу шилжиж, тэндээ 12 дугаар ангиа ёстой л дөнгөн данган төгссөн. Тааруухан сурлагатай байсан гэсэн үг л дээ. Ахлах ангид байхдаа компанийнхаа захирал Н.Эрдэнэбаяр багштайгаа анх уулзаж, сургууль дээрээ урьж ярилцлага хийж байв. Тэр үед өөрийнхөө бүтээсэн ханын самбарыг багшдаа бэлэглэж байсан минь саяхан мэт санагдаж байна. Ингэж уулзсан мөчөөс хойш хийж байгаа зүйлдээ хорхойсох болсон. Өөрийнхөө контент чиглэлийг хөгжүүлэхээр шийдэж, яг тохирно гэж бодоод "Зохиомж" дээд сургуульд найруулагч мэргэжлээр суралцаж эхэлсэн юм. Нэг жилийн дотор их зүйл өөрчлөгдөж байгааг бага багаар анзаарч эхлэв. Голч дүнгээрээ нэгдүгээр курсийн оюутнуудынхаа хэмжээнд дээгүүрт бичигддэг болсон. Өөрийнхөө сонирхлыг мэргэжлээ болгоё гэсэн сэтгэл зүй сайтар хангагдсан учраас хэнээр ч шаардуулахгүйгээр тархи, гар хоёр маань зэрэг ажиллаж эхэлсэн. Хоёр жил "Нүүдлийн зурган өгүүлэмж" компанийн дадлага хийсний эцэст гурав дахь жилээсээ үндсэн ажилтнаар ажиллах болсон. Менежментийн хуралд суух, номоо хэвлэлтээс зөөх гээд төрөл бүрийн ажилд оролцож явсаар энэ жилээс продакшнаа ахлахаар ажиллаж байна. Н.Эрдэнэбаяр багшийн тухайд гэвэл, комикоор дагнаж 10 жил ажилласан туршлагатай.

Манайхан цоо шинэ зүйлийг хийнэ гээд их хошуурдаг...

-Өмнө нь хэний ч олж, сэдвээг зүйлийг эрж хайдаг. Гэтэл энэ дэлхий дээр давтагдаагүй зүйл гэж бараг үгүй. Миний бодлоор, хуучин зүйлсээс суралцаад явбал илүү үр дүнтэй. Үндсэндээ суралцах байдлаар хуулбарла, санаа ав. Жишээлбэл, "Хандгай" цуврал 100 хувь миний контент биш. Би анх "I hate fairylанд" гэдэг комикыг уншаад, яг ийм зүйл хийх юм сан гэж хүссэний үндсэн дээр "Хандгай" цуврал бүтээгдсэн. Ингэхдээ шууд хуулчхаагүй. Би гол утга санааг нь ойлгосон, дараа нь өнгө, текст тавилт, хошигнол, загвар, харагдах байдал, хийцийг нь ч бас нарийн судалсан. Тэгээд тэр бүхнийг өөрийн арга барилд хөрвүүлсэн гэх үү дээ.

Мэргэжил сонголтод хамгийн ихээр нөлөөлдөг зүйлийн тухайд...

-Мэргэжлийг сонирхлоос эхлэлтэй гэж боддог. Харин хүний сонирхол их хувьсамтгай зүйл шиг санагддаг. Нэг зүйл дээр үргэлж тогтоод байдаггүй. Тиймээс сонирхлоо хөгжүүлэх хэрэгтэй. Цаг хугацаа биднийг хүлээхгүй шүү дээ. Өөрийнхөө сонирхлыг тодорхойлохын тулд хувь хүн өөрийгөө мэддэг байх хэрэгтэй. Өөрийгөө мэдэх нь гэгээрэхийн түвшний өндөр зүйл биш шүү. Юунд дуртай, юуг хийж чаддаг,

С.Жамбалцэрэн: Зургийг хуулбарлахдаа доош нь харуулж



Зүүн гар талаас: Багш Н.Эрдэнэбаяр, С.Жамбалцэрэн

ЗУРВАЛ ИЛҮҮ ҮР ДҮНТЭЙ

аливаа зүйлийг хийхэд миний ямар зан чанар хамгийн ихээр нөлөөлдөг вэ гэдгээ л сайтар ухаж ойлго. Гэхдээ сонирхлоо мэргэжил болголоо гээд бүх зүйл тэширлээ гэж ойлгож болохгүй. Тэрхүү мэргэжил тань нийгэмд ямар үүрэг гүйцэтгэж байгаа, ирээдүйд ямар төлөвт шилжих вэ гэдгийг судлах үүрэг танд ногдоно. Олон талаас нь судлах хэрэгтэй. Бидний мэддэгээр гэр бүлийн гишүүдээс ирж буй зөвлөмж, шахалт, үүрэг гэмээр зүйлүүд, найзуудын санал бодол ч мэргэжил сонголтод нөлөөлдөг. Гэхдээ тэдгээр хүмүүс чиний өмнөөс суралцахгүй, ажиллахгүй. Нөгөө талаар хүлээцтэй сонсдог байх нь бас л сайн чанар. Хаана ч энэ чанарыг үнэлнэ. Тиймээс хүмүүсийн санал бодлыг сонсоод эцэст нь шийдвэрээ өөрөө гаргаж, хариуцлагаа үүрч чаддаг, хийсэн сонголтдоо эзэн болдог чанарт залуус бид суралцах хэрэгтэй.

Өөрийн тань мэргэжил сонголтод ямар хүчин зүйлс нөлөөлсөн бэ?

-Багаасаа л бусад хүүхдийн адил зурагтын өмнө суугаад хүүхэлдэйн киног шимтэн үздэг байлаа. Дараа нь зураглал сайтай компьютерын тоглоомыг их сонирхж болсон. Ингэж явсаар есдүгээр ангид "Avengers"-тай анх танилцсан юм. Лавшруулаад судалтал, тус бүтээл "Marvel" хэмээх цуврал зохиолоос сэдэвлэж бүтээгдсэн гэдгийг мэдэж билээ. Цувралын талаар анхны төсөөлөлтэй болсон учраас би ч бас дотроо их зүйлийг боддог боллоо. Өөрийнхөө хэмжээнд анхны цуврал зохиолоо гаргах тодорхой амбицтай болж эхэлсэн гэсэн үг л дээ. Үүний хажуугаар бас бүжиг, илбэ, график дизайн гээд олон сонирхлыг давхцуулдаг байсан. Мэргэжил сонголт хийх хариуцлагатай үед би энэ бүхнээс аль нэгийг нь авч үлдэх, эсвэл бүгдийг нь хаях шаардлагатай болсон. Бүжгээр, илбээр ч биш харин зохиол бичээд, ханан дээр зураг зураад, түүнийгээ цуврал бүтээл болгосноор өөрийгөө бусдад илүүтэй ойлгуулж, өөрийнхөө дотоод ертөнцийг илэрхийлэх нь зөв гэж бодсон учраас би хоёр дахь сонголтыг эргэлзээгүй хийсэн.

"Хандгай" цувралын гол дүр хэрхэн бүтсэн бэ?

-Гол дүр буюу Хандгай гаргаж ирэхдээ өөрийнхөө дотоод мөн чанарыг, хувь хүнийхээ онцлог шинж чанарыг харуулахыг зорьсон. Өөрөөр хэлбэл, С.Жамбалцэрэн гэдэг хүнийг Хандгайгаар төлөөлүүлсэн гэж болно. Харин дүрийн гадаад төрхийг нь "The Shaun the sheep" болон "I hate fairylанд" зэрэг хүүхэлдэйн киноны гол дүрүүдээс санаа авч бүтээсэн. "Хандгай" цувралын гол дүрийн сул дорой, доожоогүй мэт байдал өөрт нь тун нийцтэй зохиж болохыг судалгааны явцаа олж мэдэж байв. Энэ үед би 17 настай байсан учраас өсвөр насны хүүхдийн мэдрэмжээр "Хандгай" дүрийг гаргаж ирсэн гэх үү дээ. Дүрийн бүхий л сэтгэл хөдлөл, зан авир, харилцаа, хандлага, зорилго, мөрөөдлөөс С.Жамбалцэрэн гэдэг хувь хүнийг, бяцхан ертөнцийг нь хараасай гэж хүсдэг.

Цувралууд хэдий хэр хугацаанд бүтдэг вэ?

-Хэрвээ надад цувралын ганцхан анги хийх шаардлага гарвал хамгийн ихдээ хоёроос гурван өдрийг л зарцуулна. Эхний өдөр зохиолоо бодно, дараагийн өдөр нь зурж дуусгадаг. "Хандгай"-н дөрөвдүгээр цуврал дээр долоон хүний бүрэлдэхүүнтэй ажилласан. Хамгийн түрүүнд зохиолоо гаргана. Дараа нь зохиолын дагуу багц багцаар нь бүлэглээд "storyboard"-оо хийнэ. Тэгээд зурах, будах үйл явц эхэлдэг. Ер нь хугацааг нарийн тодорхойлох боломжгүй. Гэхдээ цаг хугацаанд баригдлаа гээд чанарын шалгуураа алдахгүй байхыг хичээдэг.

Шинэ цувралын хүргэх санаа нь юу байх вэ гэдэг талаар мэдээлэл өгөхгүй юу?

-Өмнөх цувралуудын хувьд, би толгойд орсон санаагаа баяжуулан цувралаа хэрхэн үргэлжлүүлэх вэ гэдэг дээр анхаарч ирсэн байна. Харин одоо илүү зорилтот хэсэг рүү хандъя гэсэн бодолтой байгаа. Нэг үзэгдлийг хөндөөд түүн дээрээ ажиллаад явчихъя гэж их бодсоны үндсэн дээр дээрэлхэлт гэдэг сэдвийг барьж авсан. Энэ талаар холбогдох судалгааг "Нээлттэй нийгэм" ТББ-аас надад гаргаж өгсөн "Хандгай"-н дөрөвдүгээр цувралыг уншигчдад илүү наалдацтай болгох, тэдэнд нэг зүйлийг бодогдуулах байх

гэж найдаж байна. Үе тэнгийн дээрэлхэлт, хүч тэнвэргүй байдал, цахим гадуурхал гээд өргөн хүрээнд судалсан. Сонсогдох бас харагдах байдлаасаа дээрэлхэлтийг нийгэмд мэдээж сөргөөр хүлээж авдаг. Хэрээс шийдвэр гаргах нь зөв бэ гэдэгт алхам алхмаар сургадаг юм шиг санагдсан. Алсдаа таныг нийгмийн амьдралд идэвхтэй оролцоход туршлагатай, асуудлыг тодорхой хэмжээнд яриа, хэлцлийн түвшинд шийдвэрлэх чадвартай болгоход дөхөм болох ч юм бил үү. Би ч бас дээрэлхэлтээс ангид байгаагүй учраас өөрийн туршлагаас хуваалцаж байгаа нь энэ. Дээрэлхэлт гэхээр дан ганц сайн, муугийн тухай ойлголт биш гэдгийг л шинэ цувралаараа хүргэхийг зорьж ажиллаж байна.

Контентоо цаашид өөр хэлбэрээр хүргэх бодол бий юу? Жишээлбэл, анимейшнээр, дуу дүрсний хослол нь үзэгчдэд илүү их сонирхолтой байх болов уу?

-Хүргэе гэсэн маш олон санаа байгаа. Өнөөдрийг хүртэл комик хэлбэрийг түлхүү ашиглаж ирсэн. Кино, анимейшн чиглэлээр бодсон зүйл олон бий. Гол нь санаагаа л баяжуулж, зохиолынхоо чанарт анхаармаар байна.

Цувралын хамгийн чухал хэсэг нь зурган өгүүлэмжүүд. Зурах арга зүйн талаас нь зөвлөгөө өгвөл юу гэж хэлэх вэ?

-Хүн юунд хамгийн их цагаа зарцуулна, түүн дээрээ тулгуурлаж хөгжинө. Тиймээс бүтэлгүй оролдлого бүр таныг хөгжүүлж байна гэсэн үг. Яг үүн шиг зураад л байвал арга барилаа олж эхэлнэ. Бид анхандаа зургийг нүд салгалгүй харж байгаад яг дуурайлгаж зурдаг. Харин миний хувьд техник талаас нь зөвлөхөд, зургаа доош нь харуулж байгаад харж зурвал бас муугүй. Яагаад гэхээр зөв харуулж тавьсан зурагтай ажиллахад хүний зүүн тархи автоматаар ажиллаж эхэлдэг. Энэ үед та нүдэн баримжаагаар барагцаалж тухайн амьтны гадаад дүр төрхийг цаасан дээр буулгана. Харин доошоо харуулсан зургийг хуулбарлахад

зүүн тархи түгжигдэж, баруун тархи идэвхтэй ажиллан объектоо толгойдоо төсөөлж зурдаг онцлогтой. Төсөөлөн бодох чадвар нь зураг зурахад хамгийн гол нөлөө үзүүлнэ.

2019 оны Хуур мюзик фестивалийн ерөнхий зургийг гаргасан. Их олон талаар хөгжсөн байх...

Төсөөлснөөс их өөр байсан. Тус наадмын багийнхантай хамтарч ажиллаж үзэх юм сан гэдэг бодол үргэлж төрдөг байлаа. Продюсертоо энэ талаар хэлтэл намайг холбож өгсөн. Хуур мюзик фестивалийг үндэслэгчдийн нэг "BRB" компанийн захирал Ж.Энхжаргалантай уулзаад өөрийнхөө санааг илэрхийлсэн. Тэр нь наадамд оролцох уран бүтээлчдийн дүрийг "Хандгай" цувралд оруулах явдал байлаа.

Түүнийгээ хийсэн. Харин цувралаа хийх явцаа "Хандгай" цувралыг Хуур мюзик фестивалийн нүүр царай болгоё гэдэг дээр санал нэгдэж билээ. Ажиллах явцаа маш олон зүйлийг сурсан. Явц дунд гэнэтийн гэмээр тооцоолоогүй зүйлс ч ажил болоод ороод ирдэг байв. Жишээлбэл, анх зөвхөн фестивальд зориулсан цуврал бүтээх байсан бол ерөнхий зураг, нүүр царай, цаашлаад брэндбүүкийг нь хийх хэрэгтэй боллоо. Бас анимейшн. Ингээд л анх удаагаа брэндбүүк, анимейшн бүтээх том ажлын ард ажлынхаа залуутай хамтдаа гарч чадсан. Маш олон зүйл дээр алдсан. Гэхдээ алдаа бүр алсдаа намайг олон боломжийн уулзвар дээр аваачна гэж найддаг.

Продакшнаа ахалж байгаа гэсэн. Тиймээс манлайлын талаар ярилцах нь зөв байх...

-Энэ талаар нэг их олон зүйлийг ярьж чадахгүй. Учир нь би өөрөө манлайлагч ямар байх вэ гэдэг тал дээр суралцаж байгаа. Одоогоор миний ойлгосон нэг зүйл гэвэл, багийнхныгаа сайн ойлгох явдал. Багийн ахлах гэдгээр биш найзын үүднээс харилцах хэрэгтэй. Хувь хүний онцлогийг нь авч үзэх ёстой юм шиг санагдсан.

Хэтийн зорилгоосоо хуваалцахгүй юу?

-Энгийнээр хэлбэл, контентоо улам хөгжүүлэх, мөн энэ салбарт бүтээлч соёлыг бий болгох хүсэлтэй. Энэ бүхнийг хэрэгжүүлэх арга замаа тодорхойлох ёстой. Би дөнгөж л эхлүүлээд байна.

Чөлөөт цагаа юунд зарцуулдаг вэ?

-Ажлын өдрүүдэд хамгийн эртдээ 20.00-21.00 цагийн үед гэртээ харьдаг. Бүр оройтох үе ч бий. Бямба гарагт барагтаа гэрээс цухуйдаггүй. Кино үздэг. Оюуны ачааллаа хөнгөлж байгаа нь тэр л дээ. Ингэхдээ киноноос авч болох санаа юу байна гээд л ажил руугаа бас орчих гээд байдаг тал бий. Хүн дуртай зүйлээ хийгээд эхлэхээр чөлөөт цагаа ч бас түүндээ их бага хэмжээгээр зориулдаг юм байна лээ. Ням гарагт заавал ажил дээрээ ирээд сурчихсан. Шинэ долоо хоногийнхоо төлөвлөгөөг гаргаж, хийх ажлуудын бэлтгэлийг хангадаг юм.

Дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ

Монгол цэргийн музейн сан хөмрөгөөс ...



Монгол цэргийн музей нь сан хөмрөгтөө хадгалагдаж буй үзмэрийн дээжсээс жанжин Д.Сүхбаатарын хэрэглэж байсан ширээг онцлон хүргэж байна. 1911 онд Манжийн ноёрхлоос Монгол орон бүр мөсөн ангижирч, тусгаар тогтносон Богд Хаант Монгол Улсыг байгуулснаа тунхаглан таван яамыг бий болгожээ. Ийнхүү албан хэргээ явуулахад зориулан Европ маягийн хэрэгсэлтэй болохоор Хаант Орос улсын худалдааны пүүсээр дамжуулан энэхүү ширээг захиалж, яамдын сайд, орлогч нарын албан тасалгаанд хуваарилан олгож байсан түүхтэй.

Бүх цэргийн жанжин Д.Сүхбаатар 1921-1923 онд Цэргийн яамны сайдаар ажиллаж байхдаа энэхүү ширээг эзэмшиж байсан бөгөөд хожим нь Хатанбаатар С.Магсаржав, Х.Чойбалсан болон үеийн Цэргийн явдлын яамны сайд нар хэрэглэж байжээ.

Маршал Х.Чойбалсан Ерөнхий сайдын орлогч байхдаа өөрийн албан тасалгаандаа хэрэглэж байсан бөгөөд 1944 онд Д.Сүхбаатарын музейг байгуулж түүний амьдрал, үйл ажиллагаатай холбоотой эд зүйлийг цуглуулахад нь энэхүү ширээ, сандал, шүүгээг бичгийн хэрэгслийн хамтаар

шилжүүлэн өгсөн юм. Тэрээр "Энэхүү албан тасалгааны хэрэгслийг Бүх цэргийн жанжин Д.Сүхбаатар өөрөө хэрэглэж байсан түүхтэй" хэмээн хэлсэн байдаг.

Уг ширээг хатуу царс модоор бүтээсэн бөгөөд ширээний хоёр шүүгээний дөрвөн буланд арслангийн таван хуруутай тагалцаж хөл, нэг үгээр хэлбэл, бичгийн ширээг нь хоёр арслангийн найман хөл дээр тогтоосон нь Монгол төрийн бат бөх байдлыг бэлгэдсэн байдгаараа онцлогтой юм.

Д.СОДБИЛЭГТ



СОЁМБО СОНИН

"Соёмбо" сонин 96 дахь жилдээ хэвлэгдэж байна. Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА, Д.НАЦАГДОРЖ

Эрхлэгч Хурандаа Батжаргалын ОТГОНБАЯР

Эхийг "Соёмбо" сониний редакцияд бэлтгэж, "Соёмбо принтинг" хэвлэх үйлдвэрт хэвлүүлэв.

*Зар, рекламныг хямд нийтэлнэ.

*Зар, рекламны үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.

*Зохиогчийн үзэл бодол сониний нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.

*Тус сонин мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс 10018 И-мэйл хаяг: Mil_newssoyombo@yahoo.com Утас: 70001029